	14	Чулуунхороот сум	14,410.0	22,813.6	37,223.6
	Дундговь		**147,745.0**	**217,036.8**	**364,781.8**
	1	Адаацаг сум	9,723.0	15,708.1	25,431.1
	2	Баянжаргалан сум	5,760.0	9,305.6	15,065.6
	3	Говь-Угтаал сум	5,767.6	9,317.9	15,085.6
8	4	Гурвансайхан сум	7,980.4		7,980.4
	5	Дэлгэрхангай сум	10,494.3	16,954.1	27,448.4
	6	Дэлгэрцогт сум	4,600.3	7,432.0	12,032.3
	7	Дэрэн сум	6,609.0	10,677.2	17,286.2
	8	Луус сум	5,406.2	8,734.0	14,140.1

	9	Өлзийт сум	15,185.1	24,532.5	39,717.6
	10	Өндөршил сум	8,113.6	13,108.0	21,221.7
	11	Сайнцагаан сум	21,780.2	35,187.1	56,967.3
	12	Сайхан-Овоо сум	11,222.0	18,129.8	29,351.8
	13	Хулд сум	9,335.0	15,081.1	24,416.1
	14	Цагаандэлгэр сум	5,422.8		5,422.8
	15	Эрдэнэдалай сум	20,345.5	32,869.3	53,214.9
	Завхан		**251,337.2**	**289,404.9**	**540,742.1**
	1	Алдархаан сум	11,256.3		11,256.3
	2	Асгат сум	3,790.2	6,471.2	10,261.4
	3	Баянтэс сум	13,537.4	19,526.6	33,064.0
	4	Баянхайрхан сум	8,722.4	14,892.8	23,615.2
	5	Дөрвөлжин сум	12,169.8		12,169.8
	6	Завханмандал сум	6,259.7	10,689.0	16,948.7
	7	Идэр сум	8,311.1	14,191.2	22,502.2
	8	Их-Уул сум	22,982.5	39,239.2	62,221.7
	9	Нөмрөг сум	7,748.3	13,230.2	20,978.4
	10	Отгон сум	11,798.8	20,147.0	31,945.8
	11	Сантмаргаз сум	7,703.9	13,153.8	20,857.7
9	12	Сонгино сум	7,500.1	12,805.9	20,306.0
	13	Тосонцэнгэл сум	30,065.5	47,225.8	77,291.3
	14	Түдэвтэй сум	7,835.5	14,587.5	22,423.0
	15	Тэс сум	7,172.3	20,719.1	27,891.4
	16	Тэлмэн сум	14,679.0	23,031.5	37,710.4
	17	Ургамал сум	7,286.8		7,286.8
	18	Улиастай сум	22,704.0		22,704.0
	19	Цагаанхайрхан сум	4,647.0	7,935.1	12,582.1
	20	Цагаанчулуут сум	4,938.0		4,938.0
	21	Цэцэн-Уул сум	7,667.1		7,667.1
	22	Шилүүстэй сум	6,769.7	11,559.1	18,328.7
	23	Эрдэнэхайрхан сум	7,609.7		7,609.7
	24	Яруу сум	8,182.2		8,182.2
	Өвөрхангай		**345,417.9**	**542,175.3**	**887,593.2**
	1	Арвайхээр сум	37,891.5	59,475.3	97,366.9
	2	Бат-Өлзий сум	23,634.6	37,097.3	60,731.9
	3	Баянгол сум	14,160.5	22,226.6	36,387.1
	4	Баян-Өндөр сум	15,255.0	23,944.5	39,199.5
	5	Баруунбаян-Улаан сум	15,473.6	24,287.8	39,761.4
10	6	Богд сум	36,177.6	56,785.2	92,962.8
	7	Бүрд сум	12,385.5	19,440.6	31,826.1
	8	Гучин-Ус сум	13,074.0	20,521.2	33,595.1
	9	Есөнзүйл сум	10,940.2	17,172.0	28,112.2
	10	Зүүнбаян-Улаан сум	11,500.8	18,051.9	29,552.7
	11	Нарийнтээл сум	14,505.1	22,767.5	37,272.6
	12	Өлзийт сум	8,353.8	13,112.3	21,466.1
	13	Сант сум	12,761.1	20,030.0	32,791.1

	14	Тарагт сум	10,977.8	17,230.9	28,208.7
	15	Төгрөг сум	15,323.8	24,052.5	39,376.3
	16	Уянга сум	23,195.3	36,407.8	59,603.1
	17	Хайрхандулаан сум	13,928.1	21,861.8	35,789.9
	18	Хархорин сум	38,474.3	60,390.1	98,864.4
	19	Хужирт сум	17,405.5	27,320.0	44,725.4
11	**Өмнөговь**		**244,309.2**	**334,265.6**	**578,574.8**
	1	Баяндалай сум	9,728.4	16,335.4	26,063.8
	2	Баян-Овоо сум	10,214.6	17,151.8	27,366.4
	3	Булган сум	8,698.8	14,606.5	23,305.3
	4	Гурвантэс сум	36,252.6	60,873.4	97,126.0
	5	Даланзадгад сум	37,223.7		37,223.7
	6	Мандал-Овоо сум	7,626.7	12,806.4	20,433.1
	7	Манлай сум	15,493.4	26,015.7	41,509.2
	8	Ноён сум	9,960.7	16,725.4	26,686.1
	9	Номгон сум	15,384.0	25,832.0	41,216.0
	10	Сэврэй сум	11,161.9	18,742.4	29,904.4
	11	Ханбогд сум	35,700.2	59,945.6	95,645.8
	12	Ханхонгор сум	7,929.1	13,322.6	21,251.7
	13	Хүрмэн сум	8,899.7	14,943.9	23,843.5
	14	Цогт-Овоо сум	8,021.2		8,021.2
	15	Цогтцэций сум	22,014.1	36,964.5	58,978.6
12	**Сүхбаатар**		**204,559.6**	**310,275.5**	**514,835.1**
	1	Асгат сум	8,757.9		8,757.9
	2	Баруун-Урт сум	28,128.8	44,574.1	72,702.9
	3	Баяндэлгэр сум	20,031.5	31,742.7	51,774.2
	4	Дарьганга сум	13,449.6	21,312.9	34,762.5
	5	Мөнххаан сум	17,367.7	27,521.6	44,889.3
	6	Наран сум	8,649.2	13,705.9	22,355.1
	7	Онгон сум	16,675.3	26,424.4	43,099.7
	8	Сүхбаатар сум	15,689.8	24,862.8	40,552.6
	9	Түвшинширээ сум	12,749.1	20,202.7	32,951.7
	10	Түмэнцогт сум	8,776.4	13,907.5	22,683.9
	11	Уулбаян сум	10,156.7	16,094.7	26,251.3
	12	Халзан сум	6,337.0	10,041.9	16,378.9
	13	Эрдэнэцагаан сум	37,790.6	59,884.5	97,675.0
13	**Сэлэнгэ**		**294,677.6**	**400,739.7**	**695,417.4**
	1	Алтанбулаг сум	10,823.8	17,111.4	27,935.3
	2	Баруунбүрэн сум	14,068.0	22,179.8	36,247.8
	3	Баянгол сум	16,727.6	26,356.4	43,084.1
	4	Ерөө сум	28,905.6	45,665.5	74,571.1
	5	Жавхлант сум	5,818.8	9,190.6	15,009.3
	6	Зүүнбүрэн сум	6,489.1		6,489.1
	7	Мандал сум	80,611.4	126,844.0	207,455.4
	8	Орхон сум	8,094.6	12,760.7	20,855.3
	9	Орхонтуул сум	16,329.0	25,734.1	42,063.1
	10	Сайхан сум	22,767.2	36,021.3	58,788.5

	11	Сант сум	8,019.6	12,010.5	20,030.1
	12	Сүхбаатар сум	24,926.0		24,926.0
	13	Түшиг сум	9,292.3	12,909.3	22,201.6
	14	Хушаат сум	7,642.0		7,642.0
	15	Хүдэр сум	11,396.5	17,986.7	29,383.2
	16	Цагааннуур сум	16,568.3	26,163.5	42,731.8
	17	Шаамар сум	6,197.8	9,805.9	16,003.7
14	**Төв**		**261,340.7**	**368,526.7**	**629,867.4**
	1	Алтанбулаг сум	10,675.0	15,539.0	26,214.0
	2	Аргалант сум	4,467.8	6,503.3	10,971.1
	3	Архуст сум	3,312.8	4,822.1	8,134.9
	4	Батсүмбэр сум	16,090.7	23,439.4	39,530.1
	5	Баян сум	6,624.0	9,642.1	16,266.0
	6	Баяндэлгэр сум	4,983.1	7,253.5	12,236.6
	7	Баянжаргалан сум	5,900.2	8,588.5	14,488.7
	8	Баян-Өнжүүл сум	9,435.3	13,734.4	23,169.7
	9	Баянхангай сум	4,213.2	6,132.7	10,345.9
	10	Баянцагаан сум	10,305.6	15,001.3	25,306.9
	11	Баянцогт сум	5,410.9	7,876.2	13,287.2
	12	Баянчандмань сум	8,362.7	12,172.6	20,535.2
	13	Борнуур сум	11,850.0	17,249.7	29,099.7
	14	Бүрэн сум	11,389.2	16,578.3	27,967.4
	15	Дэлгэрхаан сум	7,094.9	10,327.4	17,422.3
	16	Жаргалант сум	16,889.5	24,584.3	41,473.8
	17	Заамар сум	18,015.5	26,223.3	44,238.7
	18	Зуунмод сум	18,781.5	27,338.0	46,119.5
	19	Лүн сум	8,542.4	12,434.4	20,976.9
	20	Мөнгөнморьт сум	12,031.2	17,513.1	29,544.2
	21	Өндөрширээт сум	8,205.5	11,944.0	20,149.5
	22	Сүмбэр сум	4,842.3	7,048.4	11,890.7
	23	Сэргэлэн сум	6,523.6	9,496.0	16,019.5
	24	Угтаалцайдам сум	8,177.2		8,177.2
	25	Цээл сум	8,467.2	12,324.9	20,792.1
	26	Эрдэнэ сум	15,031.4	21,880.3	36,911.8
	27	Эрдэнэсант сум	15,718.2	22,879.4	38,597.6
15	**Увс**		**305,173.4**	**307,919.2**	**613,092.6**
	1	Баруунтуруун сум	14,710.5	24,155.2	38,865.7
	2	Бөхмөрөн сум	13,107.0	21,522.2	34,629.2
	3	Давст сум	13,636.4	22,391.6	36,028.1
	4	Завхан сум	15,298.2		15,298.2
	5	Зүүнговь сум	14,093.4	23,141.9	37,235.3
	6	Зүүнхангай сум	16,902.1	27,754.0	44,656.1
	7	Малчин сум	11,968.6		11,968.6
	8	Наранбулаг сум	17,974.6		17,974.6
	9	Өлгий сум	9,940.6		9,940.6
	10	Өмнөговь сум	17,218.6		17,218.6
	11	Өндөрхангай сум	22,275.7	36,577.7	58,853.5

	12	Сагил сум	10,476.0		10,476.0
	13	Тариалан сум	12,417.6	20,390.2	32,807.8
	14	Түргэн сум	7,149.2	11,739.3	18,888.4
	15	Тэс сум	21,877.3		21,877.3
	16	Улаангом	45,770.4	75,157.0	120,927.3
	17	Ховд сум	12,897.5		12,897.5
	18	Хяргас сум	13,450.5	22,086.3	35,536.8
	19	Цагаанхайрхан сум	14,009.2	23,003.7	37,012.8
16	**Ховд**		**321,939.4**	**222,391.9**	**544,331.3**
	1	Алтай сум	30,097.1	49,343.4	79,440.5
	2	Булган сум	62,134.3	101,867.8	164,002.1
	3	Буянт сум	10,843.9		10,843.9
	4	Дарви сум	16,893.8		16,893.8
	5	Дуут сум	7,117.5		7,117.5
	6	Дөргөн сум	12,582.3	20,628.4	33,210.8
	7	Зэрэг сум	11,650.0		11,650.0
	8	Манхан сум	14,862.2	24,366.3	39,228.5
	9	Мянгад сум	10,905.6		10,905.6
	10	Мөст сум	14,533.2		14,533.2
	11	Мөнххайрхан сум	9,491.0		9,491.0
	12	Үенч сум	27,598.3		27,598.3
	13	Ховд сум	9,808.0		9,808.0
	14	Цэцэг сум	15,155.0		15,155.0
	15	Чандмань сум	15,972.1	26,186.0	42,158.1
	16	Эрдэнэбүрэн сум	8,276.2		8,276.2
	17	Жаргалант сум	44,018.8		44,018.8
17	**Хөвсгөл**		**435,882.0**	**502,687.1**	**938,569.2**
	1	Алаг-Эрдэнэ сум	18,639.9		18,639.9
	2	Арбулаг сум	12,660.9	18,985.2	31,646.1
	3	Баянзүрх сум	15,888.2	23,731.2	39,619.4
	4	Бүрэнтогтох сум	13,009.3	19,316.6	32,325.8
	5	Галт сум	21,013.6	28,801.8	49,815.5
	6	Жаргалант сум	19,865.3	27,147.9	47,013.2
	7	Их-Уул сум	12,632.5	18,702.2	31,334.7
	8	Рашаант сум	13,294.1	20,099.2	33,393.3
	9	Рэнчинлхүмбэ сум	29,535.4	41,758.0	71,293.4
	10	Тариалан сум	22,408.0	29,934.5	52,342.5
	11	Тосонцэнгэл сум	11,123.6	16,447.9	27,571.4
	12	Төмөрбулаг сум	12,178.6	17,973.9	30,152.5
	13	Түнэл сум	12,117.8	18,117.0	30,234.8
	14	Улаан-Уул сум	26,155.6	38,676.9	64,832.5
	15	Ханх сум	18,519.7	28,005.3	46,525.0
	16	Цагаан-Уул сум	22,844.3	31,851.5	54,695.8
	17	Цагааннуур сум	14,824.9	22,420.0	37,244.9
	18	Цагаан-Үүр сум	19,363.2		19,363.2
	19	Цэцэрлэг сум	25,012.1	36,192.6	61,204.7
	20	Чандмань-Өндөр сум	14,052.7	21,251.0	35,303.8

	21	Шинэ-Идэр сум	11,513.6	17,408.0	28,921.5
	22	Эрдэнэбулган сум	17,105.7	25,866.3	42,972.1
	23	Мөрөн сум	52,123.2		52,123.2
18	**Хэнтий**		**244,623.9**	**349,272.7**	**593,896.6**
	1	Батноров сум	17,063.9	23,506.2	40,570.1
	2	Батширээт сум	13,726.8	21,161.3	34,888.1
	3	Баян-Адарга сум	9,743.3	14,882.8	24,626.1
	4	Баянмөнх сум	6,056.4	9,298.5	15,354.8
	5	Баян-Овоо сум	7,632.6	11,729.9	19,362.5
	6	Баянхутаг сум	9,061.9		9,061.9
	7	Биндэр сум	16,995.8	25,967.7	42,963.5
	8	Бор-Өндөр сум	27,982.7	39,644.8	67,627.5
	9	Галшар сум	11,811.6	18,253.6	30,065.2
	10	Дадал сум	15,803.1	24,127.0	39,930.1
	11	Дархан сум	9,122.5	14,038.5	23,161.0
	12	Дэлгэрхаан сум	9,823.6	13,106.5	22,930.2
	13	Жаргалтхаан сум	7,355.9	11,269.0	18,624.9
	14	Мөрөн сум	4,956.3	7,617.0	12,573.4
	15	Норовлин сум	12,718.7	19,525.1	32,243.8
	16	Өмнөдэлгэр сум	23,576.1	34,703.9	58,280.0
	17	Хэрлэн сум	33,034.8	47,934.3	80,969.0
	18	Цэнхэрмандал сум	8,157.9	12,506.5	20,664.5
19	**Дархан-Уул**		**251,877.9**	**331,104.4**	**582,982.2**
	1	Дархан сум	85,699.7	112,656.0	198,355.8
	2	Орхон сум	26,555.1	34,907.8	61,463.0
	3	Хонгор сум	75,685.8	99,492.3	175,178.1
	4	Шарын гол сум	63,937.2	84,048.2	147,985.5
20	**Орхон**		**272,725.4**	**408,121.8**	**680,847.2**
	1	Баян-Өндөр сум	129,111.4	182,060.4	311,171.8
	2	Жаргалант сум	143,614.0	226,061.4	369,675.4
21	**Говьсүмбэр**		**44,706.0**	**75,193.4**	**119,899.4**
	1	Баянтал сум	6,231.9	10,481.8	16,713.7
	2	Сүмбэр сум	22,182.4	37,309.8	59,492.2
	3	Шивээговь сум	16,291.6	27,401.8	43,693.4
	НИЙТ		**5,524,605.0**	**6,534,370.3**	**12,058,975.3**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ

2020 он

Агуулга

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ 2
1.1. Дэлхийн эдийн засаг, гадаад орчин 2
1.2. Монгол Улсын эдийн засаг 7
2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ 6 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ 11
2.1. Төсвийн орлогын эхний 6 сарын гүйцэтгэл 11
2.2. Төсвийн зарлагын эхний 6 сарын гүйцэтгэл 13
3. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ 14
4. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ 17
5.НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ 21
5.1. Төсөвт тодотгол хийх үндэслэл 21
5.2. Төсвийн тодотголд баримтлах үндсэн зарчмууд 21
5.3. Төсвийн тодотголоор авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд 22
6. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ 32
7. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН 33
8. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ 33
9. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 35
9.1. Төсвийн тэнцэл 35
9.2. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр 35
10. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА 36
11.МАКРО ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ 38
12. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН 39
13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН 42

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1. Дэлхийн эдийн засаг, гадаад орчин

1.1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Дэлхийн эдийн засаг 2020 онд 4.9 хувиар агшихаар байна.

Дэлхийн эдийн засаг 2020 онд 4.9 хувиар агших бол 2021 онд 5.4 хувиар өснө гэж Олон улсын валютын сан (ОУВС) таамаглаж байна. Энэ нь дэлхий дахиныг өргөн хүрээнд хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтаас үүдэлтэйгээр дэлхийн эдийн засгийн идэвхжил саарч байгаатай холбоотой юм. 2020 онд хөгжингүй орнуудын эдийн засаг 8.0 хувиар, хөгжиж буй орнуудын эдийн засаг 3.0 хувиар тус тус агшихаар байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлт ийнхүү буурахад нөлөө үзүүлж байна.

Хүснэгт № 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт

Бүс нутаг	2019	2020	2021
Дэлхий	2.9	-4.9	5.4
Хөгжингүй орнууд	1.7	-8.0	4.8
АНУ	2.3	-8.0	4.5
Евро бүс	1.3	-10.2	6.0
Япон	0.7	-5.8	2.4
Хөгжиж буй орнууд	3.7	-3.0	5.9
Хөгжиж буй Азийн орнууд	5.5	-0.8	7.4
ОХУ	1.3	-6.6	4.1
БНХАУ	6.1	1.0	8.2

Эх үүсвэр: ОУВС-гаас 6 дугаар сард нийтэлсэн "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайлан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалттай тэмцэх хүрээнд улс орнуудын төсвийн зарлага өсөж байгаа бол эдийн засгийн хямрал, хөл хорионы улмаас татварын орлого нь хумигдаж байна. Иймд улс орнууд төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн уналтыг сааруулах бодлого хэрэгжүүлж байна.

АНУ-ын эдийн засаг 2020 онд 8.0 хувиар агших бол 2021 онд 4.5 хувиар өсөхөөр таамаглагдаж байна. АНУ-ын эдийн засаг 2020 оны 2 дугаар улиралд 32.9 хувиар агшиж, ажилгүйдлийн түвшин 6 дугаар сарын байдлаар 11.1 хувьд хүрч өсжээ. ОУВС-гийн зүгээс коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр АНУ-ын 2020 оны эдийн засаг 8.0 хувиар буурна гэж таамаглаж байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2020 онд 1.0 хувь, 2021 онд 8.2 хувиар өсөхөөр төсөөлөгдөж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн улмаас 2020 оны эхний улиралд 6.8 хувиар агшаад байсан БНХАУ-ын эдийн засаг 2 дугаар улиралд сэргэж 3.2 хувиар өслөө. Улмаар ОУВС тус улсын эдийн засгийг 2020 онд 1.0 хувиар өснө гэж таамаглаж байна. "Oxford Economics" байгууллагын үзэж байгаагаар БНХАУ-ын эдийн засаг 2020 оны сүүлийн хагаст 6.0 хувиар өсөж, жилийн өсөлт 2.5 хувьд хүрэхээр байна.

График № 1. V хэлбэрт БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, хувь



Эх үүсвэр: БНХАУ-ын Статистикийн үндэсний хороо

БНХАУ-д коронавируст халдвар (КОВИД-19) тархсанаас хойш нийт 84,756

тохиолдол бүртгэгдсэнээс 79,398 хүн эдгэжээ. 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар идэвхтэй тохиолдлын тоо 724 байна.

График № 2. БНХАУ дах коронавируст халдвар (КОВИД-19)-ын байдал, 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар



Эх үүсвэр: Worldometers цахим хуудас, 2020.08.13

БНХАУ коронавируст халдвар (КОВИД-19)-ын дэгдэлтийг хяналтдаа байлгаж байгаа бөгөөд манай улстай хиллэж буй бүс нутагт халдварын тохиолдол бага байна.

График № 3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол БНХАУ-д

Эх сурвалж: Жон Хопкинсийн Их Сургуулийн дэргэдэх коронавируст халдвар (КОВИД-19)-ын судалгааны төв

БНХАУ-ын Засгийн газраас энэ оны эдийн засгийн өсөлтийн зорилтот түвшинг зарлаагүй ч ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын зорилтот хувь хэмжээг 3.6 хувь болгон өсгөж, Засгийн газрын болон орон нутгийн тусгай бондын хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгаа тэлэх бодлого хэрэгжүүлж байна.

Үүний үр дүнд БНХАУ-ын гадаад худалдаа, аж үйлдвэрийн салбар эргэн сэргэв.

График № 4. БНХАУ-ын эдийн засгийн идэвхжилийг илэрхийлэх аж үйлдвэрийн түрүүлэгч индекс (PMI)



Эх үүсвэр: БНХАУ-ын Статистикийн үндэсний хороо

График № 5. БНХАУ-ын гадаад худалдааны динамик 2020 оны эхний хагас жилд, хувь



Эх үүсвэр: БНХАУ-ын Статистикийн үндэсний хороо

Евро бүсийн эдийн засаг 2020 онд 10.2 хувиар агшихаар төсөөлөгдөж байна. Бүгд Найрамдах Итали Улс, Испанийн Вант Улс, Бүгд Найрамдах Франц зэрэг улсуудад коронавируст халдвар (КОВИД-19) өргөн тархсанаас шалтгаалан Евро бүсийн эдийн засаг 2020 онд 10.2 хувиар буурах бол 2021 онд 6.0 хувиар өснө гэж

ОУВС-гийн зүгээс таамаглаж байна. Тус бүсийн эдийн засаг 2020 оны 2 дугаар улиралд 12.1 хувиар агшаад байгаа бөгөөд Европын төв банкнаас коронавируст халдвар (КОВИД-19)-ын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор 1.35 их наяд еврогийн үнэт цаас худалдан авах замаар эдийн засагт мөнгө нийлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Япон Улсын эдийн засаг 2020 онд 5.8 хувиар агшихаар байна. Хэрэглээний татварын өсөлт, байгалийн гамшгаас шалтгаалан 2019 оны 4 дүгээр улиралд 7.2 хувиар агшаад байсан Япон Улсын эдийн засаг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалтын нөлөөгөөр 2020 оны эхний улиралд дахин 2.2 хувиар агшаад байна. Япон Улсын Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын дэгдэлтийн сөрөг нөлөөг бууруулахад зориулж 234.0 орчим их наяд иений хоёр багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. ОУВС-гаас тус улсын эдийн засгийг 2020 онд 5.8 хувиар агших бол 2021 онд 2.4 хувиар өснө гэж таамаглаж байна.

ОХУ-ын эдийн засаг 2020 онд 6.6 хувиар агшихаар байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цах тахлаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн агшилтын нөлөөгөөр ОХУ-ын эдийн засаг 2020 онд 6.6 хувиар буурах бол 2021 онд 4.1 хувиар өснө гэж ОУВС-гаас таамаглажээ. Тус улсын Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг 5 их наяд рублийн багц арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хоёр дахь давалгаа болсон тохиолдолд дэлхийн эдийн засаг халдварын өмнөх түвшинд хүрэхэд хамгийн багадаа 2 жил шаардагдана.

График № 6. Дэлхийн ДНБ-ий төсөөлөл, их наяд ам.доллар



Эх үүсвэр: OECD, Эдийн засгийн төлөв тайлан – 2020 оны 06 дугаар сар

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын 2020 оны 6 сард гаргасан Эдийн засгийн төлөв байдлын тайланд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хоёр дахь давалгаа тархсан тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд 2.8 хувь байх ба эдийн засаг сэргэж 2019 оны түвшинд эргэн очиход шаардагдах хугацааг хамгийн багадаа 2 жил гэж таамаглаж байна.

1.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс

Зэсийн үнэ 2019 онд дунджаар 6,004.6 ам.доллар байсан бол 2020 оны эхний 6 сарын дунджаар 5,490.0 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буурсан байна. Энэ нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалттай холбоотойгоор дэлхийн эдийн засгийн нийт эрэлт саарсантай холбоотой юм.

Хэдийгээр зэсийн үнэ 2020 оны эхний хагаст буурсан ч судалгааны байгууллагуудаас 2020 оны үлдэх хугацаанд зэсийн үнэ эргэн сэргэхээр төсөөлж байна. Олон улсын шинжээчдийн

төсөөллөөр зэсийн дундаж үнэ 2020 оны үлдэх хугацаанд 6,400.0 ам.доллар, 2020 оны жилийн дунджаар 5,944.8 ам.доллар орчимд байхаар байна.

График № 7. Зэсийн үнийн төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмберг

Алт

Алтны үнэ 2019 онд дунджаар унц тутамд 1,393.4 ам.доллар байж, өмнөх оны дунджаас 9.8 хувиар өсжээ. Алтны бодит хэрэглээ 2019 онд өсөөгүй хэдий ч, зах зээл дээрх тодорхой бус байдалтай холбоотойгоор алтанд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Мөн Төв банкууд алт худалдан авалтаа нэмэгдүүлсэн, АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ гурван удаа бууруулсан зэрэг нь алтны үнэ өсөхөд нөлөөлсөн байна.

График № 8. Алтны үнийн төсөөлөл, ам.доллар/трой унц



Эх үүсвэр: Блүүмберг

Олон улсын шинжээчид алтны ханшийг 2020 онд үргэлжлэн өснө гэж таамаглаж байна. Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 онд 1,770.0 ам.доллар орчимд, 2020 оны сүүлийн хагаст дунджаар 1,900.0 ам.доллар байх төлөвтэй байна.

Газрын тос

Брент (Brent) газрын тосны үнэ 2019 онд дунджаар 64.2 ам.доллар байж, өмнөх оны дунджаас 10.5 хувиар буурсан байна. Судлаачдын таамгаар газрын тосны дундаж үнэ 2020 оны хоёрдугаар хагаст өсөлттэй байна.

График № 9. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/баррель



Эх үүсвэр: Блүүмберг

Нүүрс

Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2019 онд 15.0 хувиар буурч, 177.0 ам.долларт хүрсэн байна.

График № 10. Нүүрсний үнийн төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмберг

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн улмаас 2020 оны эхний хагас жилийн байдлаар нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ буурсан ч БНХАУ-ын эдийн засаг хурдтай сэргэж байгаатай холбоотойгоор нүүрсний үнэ цаашид өснө гэж олон улсын судалгааны байгууллагууд таамаглаж байна.

Төмрийн хүдэр

Төмрийн хүдрийн үнэ 2019 онд дунджаар 93.1 ам.доллар байж, өмнөх оноос 35.0 орчим хувиар өссөн байна. Цаашид мөн өсөх төлөвтэй байгаа талаар шинжээчид төсөөлж байна.

1.1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг олон улсад авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд болон түүний үр нөлөө

Дэлхийн дахинаа хурдацтайгаар тархаж буй коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас үүдэх эрсдэлийг бууруулах чиглэлээр улс орон бүр өөр өөрсдийн эдийн засгийн чадавх, нөөц боломждоо тохирсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт № 2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг олон улсад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлсэн улсууд
1	Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, вирусийн оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж авах.	Аргентин, Австрали, Бразил, Канад, БНХАУ, Франц, ХБНГУ, БНЭУ, Индонези, АНУ, ӨАБНУ, Испани, Итали, Япон, ОХУ, Саудын Араб, БНСУ, Мексик
2	Зорилтот бүлэгт олгох тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг мөнгөн дэмжлэгийг нэмэгдүүлэх.	Аргентин, ХБНГУ, БНЭУ, Индонези, Канад, Франц, Итали, АНУ, Англи, Турк, Япон, БНСУ, Испани, ОХУ, Мексик
3	Аж ахуйн нэгжүүдийн банкнаас авах зээлийн батлан даалт гаргах зэргээр зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.	Аргентин, Австрали, Бразил, Франц, ХБНГУ, Итали, ОХУ, БНСУ, ӨАБНУ, Турк
4	Иргэд, аж ахуйн нэгжүүдийг татвараас чөлөөлөх.	Бразил, Канад, БНХАУ, Индонези, БНСУ, ОХУ
5	Иргэд, аж ахуйн нэгжүүдийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх.	Аргентин, БНХАУ, Франц, ХБНГУ, Энэтхэг, Индонези, АНУ, Испани, Итали, ОХУ
6	Татвар төлөх, тайлагнах хугацааг хойшлуулах.	Франц, ХБНГУ, Энэтхэг, Индонези, Итали, АНУ, Турк, Япон, ОХУ, БНСУ
7	Төсвийн гүйцэтгэлийг сайжруулах үүднээс тендерийг эрчимжүүлэх.	Аргентин, Мексик
8	Экспортыг нэмэгдүүлэх, импортын татвараас чөлөөлөх, дотоодын нийлүүлэлтийн дэмжих зэргээр өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний хомсдол, зохиомол үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх.	Аргентин, ОХУ

Эх сурвалж: Олон Улсын Валютын Сангийн цахим хуудас

Хүснэгт № 3. Хөгжиж буй улс орнуудын 2019 оны төсвийн алдагдал болон 2020 оны хүлээгдэж буй төсвийн алдагдлын харьцуулалт, ДНБ-д эзлэх хувиар



Хүснэгт № 4. Хөгжингүй улс орнуудын 2019 оны төсвийн алдагдал болон 2020 оны хүлээгдэж буй төсвийн алдагдлын харьцуулалт, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: The Economist сэтгүүл, 2020.06.18

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед олон орнууд татварын чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд татвараас чөлөөлөх, татварын хувь хэмжээг бууруулах, татвар төлөх, тайлагнах хугацааг хойшлуулах буюу торгууль алдангиас чөлөөлөх, алдагдал шилжүүлэх хугацааг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ багтана. Дэлхийн 59 улс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын, 74 улс хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлт, 41 улс нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлжээ. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн нөлөөгөөр нэмэгдэж буй төсвийн зарлагын өсөлтөөс гадна эдийн засгийн хямрал, хөл хорионы улмаас буурч буй төсвийн орлого нь улс орнуудад төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлж байна.

1.2. Монгол Улсын эдийн засаг

1.2.1. 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2020 оны эхний улиралд 7.4 их наяд төгрөгт хүрч (оны үнээр тооцсон), эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар буурсан байна. Үүний 69 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэр, 19 хувь нь тээвэр ба агуулахын салбар, 12 хувь нь худалдааны салбарын бууралтаас шалтгаалжээ.

График № 11. Эдийн засгийн өсөлт, хувь



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотойгоор БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс хот доторх болон хот хоорондын хөдөлгөөнийг хорьж, компани, үйлдвэр, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон.

Хүснэгт № 5. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

	2017	2018	2019	2020
	Жил бүрийн эхний улирал			
Эдийн засгийн өсөлт	**4.2**	**6.2**	**8.6**	**-10.7**
Хөдөө аж ахуй	**3.9**	**3.7**	**2.1**	**14.0**
Үйлдвэрлэл	**-1.8**	**5.6**	**12**	**-19.6**
Уул уурхай	-5.4	3.8	14.4	-29.5
Боловсруулах аж үйлдвэр	22.9	7.9	7.3	5.1
Цахилгаан	3.0	9.6	3.7	6.8
Барилга	-24.9	27.2	7.3	12.0
Үйлчилгээ	**5.8**	**4.4**	**7.6**	**-6.8**
Худалдаа	15.5	6.0	15.1	-11.1
Тээвэр	12.6	0.1	3.4	-30.6
Мэдээлэл, холбоо	3.0	6.4	10.7	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.8	4.7	5.2	0.7
Цэвэр татвар	**18.4**	**16.4**	**5.5**	**-7.9**

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хоёр сар гаруй үргэлжилсэн БНХАУ дахь хөл хорионы улмаас манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурлаа. Уул уурхай салбарын уналтыг даган тээвэр болон худалдааны салбарын орлого мөн буурснаар эдийн засаг огцом агшлаа[1].

Харин нэгдүгээр улиралд хөдөө аж ахуй, барилга, боловсруулах зэрэг салбарын үйлдвэрлэл өсжээ.

Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны эхний 6 сарын байдлаар 5.3 тэрбум ам.долларт хүрч 2019 оны мөн үеэс 22.6 хувиар буурсан бол гадаад худалдааны тэнцэл 368.2 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 64.8 хувиар буурсан байна.

График № 12. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт, импорт, тэнцэл, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Экспортоор 2,828.3 сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар буурсан үзүүлэлт юм. 2020 оны эхний хагас жилийн байдлаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас улбаалан манай улсын гол нэрийн бүтээгдэхүүн нүүрсний экспорт 55.3 хувиар, зэсийн баяжмал 30.3 хувиар, газрын тос 81.1 хувиар тус тус

[1] *2020 оны нэгдүгээр улиралд нүүрсний экспорт 60.6 хувиар, зэсийн баяжмалын экспорт 30.3 хувиар, газрын тосны экспорт 79.9 хувиар тус тус буурснаас уул уурхайн салбар 29.5 хувиар, тээврийн салбар 30.6 хувиар буурч, Монгол Улсын эдийн засаг 2020 оны нэгдүгээр улиралд 10.7 хувийн уналттай гарав.*

буурсан нь экспортын бууралтад голлон нөлөөлжээ.

Импортоор 2,460.1 сая ам.долларын бараа, түүхий эд авсан нь өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар буурчээ. Импортын бууралтад тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, эрдэс бүтээгдэхүүн, машин механизм, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн бууралт голлон нөлөөлсөн байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2020 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 679.2 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Шууд хөрөнгө оруулалт (цэвэр) 898.2 сая ам.доллар болж 16.9 хувиар буурсан болон Худалдаа, хөгжлийн банк үнэт цаасаа эргүүлж төлсөн нь төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны ашиг буурахад нөлөөлжээ. Санхүүгийн данс 399.2 сая ам.долларын ашигтай гарлаа.

График № 13. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар



Эх үүсвэр: Монголбанк

Гадаад валютын улсын нийт албан нөөц эхний хагас жилийн байдлаар 3.6 тэрбум ам.долларт хүрсэн нь импортын 8.5 сарын хэрэгцээг хангаж, "хүрэлцээт" түвшинд байна. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2020 оны эхний 6 сарын байдлаар 10.8 тонн болж, өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн нь гадаад валютын нөөцөд эергээр нөлөөлсөн байна.

Инфляц

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн уналтын нөлөөгөөр дотоодын шатахууны жижиглэнгийн үнэ буурч, бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв. 2020 оны эхний хагаст эдийн засгийн идэвхжил саарсантай холбоотойгоор эрэлтийн гаралтай инфляцын дарамт буурч, инфляцын түвшин 2020 оны 6 дугаар сарын байдлаар 2.8 хувьд хүрээд байна.

1.1.2. 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Өнгөрсөн 3 жилд Монгол Улсын Засгийн газар эдийн засаг сэргэхийн хэрээр төсвийн алдагдлыг бууруулж, сахилга батыг чанд баримтлан, эдийн засгийн хэт халалтаас сэргийлэх мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж ирсэн.

График № 14. Эдийн засгийн мөчлөг ба төсвийн бодлогын төлөв байдал



Эх үүсвэр: Сангийн яам

Засгийн газрын зүгээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн идэвх буурахаас сэргийлэх, иргэдийн орлогыг дэмжих, мөн дотоодын үнийн тогтвортой байдлыг хамгаалах, хөдөлмөрийн болон санхүүгийн зах зээлийг дэмжих, санхүүжилт татрахаас сэргийлэх эдийн засгийн цогц арга хэмжээ авч байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эдийн засгийг сэргээх цогц

арга хэмжээ авч, төсөв, мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлж байгаагийн үр дүнд 2020 оны сүүлийн хагаст эдийн засгийн идэвхжил нэмэгдэж оны эцэст өсөлт -1.0 хувьд хүрэхээр тооцлоо.

Гадаад худалдаа

2020 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 11.7 тэрбум ам долларт, гадаад худалдааны тэнцэл 520.0 сая ам.долларт хүрэхээр тооцлоо.

Экспортын хэмжээ 6.1 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна. Шинжээчдийн таамгаар 2020 оны сүүлийн хагаст нүүрс, газрын тос, зэсийн баяжмал, алт зэрэг уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөхөөр байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөлд экспортын тээвэрлэлтэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол-Хятадын хилийн боомтын “Ногоон гарц”-ын түр журмыг хэрэгжүүлэхээр хоёр тал тохиролцож ерөнхий журмыг батлан мөрдүүлж эхлээд байна. Уг ажлын хүрээнд нүүрсний тээвэр хийж буй жолооч нарын нөхцөлийг сайжруулан харилцан шуурхай нэвтрүүлэн нүүрсний экспортыг нэмэгдүүлэхээр тооцлоо.

Эдийн засгийн идэвхжил 2020 оны сүүлийн хагаст сэргэхээр байгаатай холбоотойгоор уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбаруудын үйл ажиллагаа тэлж, үйлдвэрлэлийн орц, тоног төхөөрөмж, автомашин, эд ангийн импорт өсөх төлөвтэй байна. Импортын хэмжээ 2020 онд 5.6 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Төлбөрийн тэнцэл

2020 оны сүүлийн хагаст гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэхээр байгаа, мөн томоохон дүнтэй бонд, зээлийн эргэн төлөлт зэрэг валютын гадагшлах урсгал байхгүй тул төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд дарамт бага байна.

Инфляц

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалттай холбоотойгоор нийт эрэлт саараад байгаа тул инфляцын түвшин 2020 онд Монголбанкны зорилтот түвшингээс бага байхаар байна.

1.1.3. Макро эдийн засгийн 2021-2023 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2021-2023 онд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 6.0 орчим хувьд хүргэхээр зорьж байна.

Хүснэгт № 6. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий төсөөлөл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2021	2022	2023
Өсөлт, хувь	7.6	5.2	6.0
уул уурхайн	*10.0*	*-0.1*	*7.9*
уул уурхайн бус	*7.0*	*6.4*	*4.6*
ДНБ	40,860	44,402	48,454

Эх үүсвэр: Сангийн яам

Газрын тосны үйлдвэр болон төмөр замыг барьж байгуулах, цэвэрлэх байгууламж барих, барилга, угсралтын ажил идэвхжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Хурдацтай сэргэж буй БНХАУ-ын зах зээлд ойр байдал, түүхий эдийн чанар, өртгөөр өрсөлдөх чадвараа тогтвортой хадгалах замаар экспортоо нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Гадаад худалдаа

График № 15. Гадаад худалдааны төсөөлөл, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Сангийн яам

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2021-2023 онд дунджаар 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Дунд хугацаанд гадаад худалдааны нийт эргэлт нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахаар төсөөлж байна.

Төлбөрийн тэнцэл

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарснаар валютын орох урсгал нэмэгдэж, урсгал дансны алдагдал буурахаар байна. 2021-2023 онд Мазаалай бонд, Монгол Улсын Хөгжлийн банкны Синдикат зээл, Чингис бонд, МИК ОССК-ийн бонд, Гэрэгэ бонд, Самурай бонд, Хөгжлийн банкны бонд, БНХАУ-ын Ардын банктай хийсэн своп хэлцэл зэрэг томоохон дүнтэй үнэт цаас, зээлийг төлөх хуваарьтай байгаа тул санхүүгийн дансны дарамтыг бууруулахад чиглэсэн бэлтгэл ажлыг эртнээс хангах шаардлагатай байна.

1.1.4. Макро эдийн засгийн төсөөлөл боловсруулахад ашигласан аргачлал, тооцооны товч танилцуулга

ОУВС-гийн боловсруулсан Санхүүгийн программчлал /Financial Programming/ загварыг суурь болгон ашиглаж Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг уялдуулан тооцлоо. Мөн эдийн засгийн бүтцийн, ерөнхий тэнцвэрийн, динамик болон эконометрик загваруудын үр дүнтэй харьцуулан эдийн засгийн хэтийн төсөөллийг боловсруулж байна.

2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ 6 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Төсвийн орлогын эхний 6 сарын гүйцэтгэл

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал нь эрэлт талаасаа хорио цээрийн улмаас бизнесийн үйл ажиллагаа хумигдсан, худалдан авалт буурснаас иргэд аж ахуйн нэгжийн орлого буурсан харин нийлүүлэлт талаасаа хилийн хязгаарлалтаас улбаалан улс орнуудын гадаад худалдаа саарсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт багассан зэргээс голчлон шалтгаалж байна.

Ингэснээр улс орнуудын төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс ихээхэн хэмжээгээр буурах нөхцөл байдлыг үүсгэлээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2020 оны эхний 6 сарын байдлаар 4,358.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1,212.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,190.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт № 7. Эхний 6 сарын гүйцэтгэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019.6 Гүйц (1)	2020.6 Төл (2)	2020.6 Гүйц (3)	Зөрүү (3)-(2)
Нийт орлого	**5,548.8**	**5,570.9**	**4,358.7**	**-1,212.2**
Тогтворжуулалтын сан	31.8	56.0	12.0	-44.1
Ирээдүйн өв сан	616.6	365.9	246.5	-119.4
Тэнцвэржүүлсэн орлого	**4,900.4**	**5,149.0**	**4,100.3**	**-1,048.8**
Татварын орлого	**4,446.2**	**4,590.5**	**3,742.9**	**-847.6**
Орлогын албан татвар	1,142.0	1,219.0	919.6	-299.4
Нийгмийн даатгалын орлого	924.6	1,062.6	786.1	-276.5
Хөрөнгийн албан татвар	88.0	105.3	79.6	-25.7
НӨАТ	1,050.5	998.3	953.6	-44.7
Онцгой албан татвар	427.1	432.1	365.2	-66.9
Тусгай зориулалт	7.5	7.2	8.0	0.8
Гадаад үйл ажиллагаа	362.9	386.4	335.8	-50.6
Бусад татвар	443.0	379.5	294.8	-84.7
Татварын бус орлого	**454.3**	**558.6**	**357.4**	**-201.1**

Үүнээс Тэнцвэржүүлсэн нийт орлого 1,048.8 тэрбум төгрөгөөр, Ирээдүйн өв сан 119.4 тэрбум төгрөгөөр, Төсвийн тогтворжуулалтын сан 44.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн хэмжээнээс буурчээ. Нэгдсэн төсвийн нийт орлого төлөвлөсөн хэмжээнээс 1.2 их наяд төгрөгөөр буурахад дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт саарч, дотоодын хэрэглээ, экспорт, импорт буурч, бизнесийн идэвхжил багассан нь гол нөлөө үзүүлсэн байна.

График № 16. Төсвийн орлогын 6 дугаар сарын гүйцэтгэлийн бууралт /шалтгаанаар/



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр ашигт малтмал, газрын тосны экспорт буурав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас энэ оны эхний 6 сарын байдлаар нийт экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар буюу 1.1 тэрбум ам.долларoор буурсан байна. Үүний дийлэнх хэсэг буюу 858 сая ам.долларын бууралт нь уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний экспорт буурснаас шалтгаалжээ. Ашигт малтмал, газрын тосны экспортын хэмжээ ийнхүү буурснаар нэгдсэн төсвийн нийт орлого төлөвлөсөн хэмжээнээс 647.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр импорт буурав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэн аж ахуйн нэгж, иргэдийн хэрэглээ хумигдаж байгаатай холбогдуулан энэ оны эхний 6 сарын байдлаар импортын хэмжээ өмнөх оны

мөн үеэс 15 хувь буюу 433.6 сая ам.долларoор буурсан байна. Импортын хэмжээ ийнхүү буурснаас хамаарч төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 212.4 тэрбум төгрөгөөр буурчээ.

Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгжүүдийг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоор дэмжлэг үзүүлэв. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, дотоодын эрэлт, импорт, экспорт буурсан хүндрэлтэй цаг үед хувийн хэвшилд ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын шимтгэл, цалинд ногдуулах албан татвараас чөлөөлөх, 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлөх, түрээсийн төлбөр бууруулсан аж ахуйн нэгжүүдийн татварыг хөнгөлөх, татварын алданги, торгуулиас чөлөөлөх, хүнсний гол нэр төрлийн бараа, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг нэн шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зэрэг арга хэмжээ авсан. Ийнхүү иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эдийн засгийг эрчимжүүлэх чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлснээр энэ оны эхний 6 сарын байдлаар нийт 352 тэрбум төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг 700 мянга гаруй иргэн, 105 мянга гаруй аж ахуйн нэгжид эдлүүлсэн байна.

2.2. Төсвийн зарлагын эхний 6 сарын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7,658.7 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 6,298.3 тэрбум төгрөгийн буюу 82.2 хувийн, улсын төсвийн зарлага 5,879.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 5,110.7 тэрбум төгрөгийн буюу 86.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт № 8. Нэгдсэн төсвийн нийт зарлагын 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөг

Төсвийн төрөл	ӨО-ны мөн үе	Төлөв-лөгөө	Гүйц	Гүйц %
	.1.	.2.	.3.	.3/2.
Нэгдсэн	**4,708.3**	**7,658.7**	**6,298.3**	**82.2%**
УТ	3,775.4	5,879.4	5,110.7	86.9%
ОНТ	1,257.7	2,092.8	1,413.5	67.5%
НДС	1,009.6	1,252.8	1,187.3	94.8%
ЭМДС	163.7	256.4	198.3	77.3%

Нэгдсэн төсвийн төсвийн урсгал зардал 5,050.8 тэрбум төгрөгт хүрч 82.2 хувийн гүйцэтгэлтэй, хөрөнгийн зардал 1,228.9 тэрбум төгрөгт хүрч 70.2 хувийн гүйцэтгэлтэй, эргэж төлөгдөх цэвэр зээл 18.7 тэрбум төгрөгт хүрч 20.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт № 9. Нэгдсэн төсвийн нийт зарлагын 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	ӨО-ы мөн үе	Төлөв.	Гүйцэтгэл	
	.1.	.2.	.3.	.4=3/2.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛ	**4,708.3**	**7,658.7**	**6,298.3**	**82.2%**
Урсгал зардал	3,962.3	5,819.6	5,050.8	86.8%
Хөрөнгийн зардал	636.1	1,749.6	1,228.9	70.2%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	109.9	89.5	18.7	20.9%

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд зөвхөн цар тахлын эрсдэлтэй нүүр тулан тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, хил хамгаалах зэрэг тусгай үүргийн байгууллагуудын зардал, бусад төсөвт байгууллагуудын

цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, бусад зайлшгүй шаардлагатай зардлыг ямар нэгэн хүндрэлгүйгээр бүрэн санхүүжүүллээ. Харин бүх шатны төсөвт байгууллагуудын бичиг хэрэг, тавилга, эд хогшил, урсгал засвар, гадаад томилолт, татаас, урсгал шилжүүлэг болон бусад бараа үйлчилгээний зардал зэрэг тэвчиж болох зардлыг бүрэн болон хэсэгчлэн зогсоох замаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг бий болголоо.

Хүснэгт № 10. 2020 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын эхний хагас жилийн гүйцэтгэл, эдийн засгийн томсгосон ангиллаар /тэрбум төгрөг/

Төсвийн төрөл	Нийт зарлага ба цэвэр зээл	Урсгал зардал				Хөрөнгө оруулалт	Эргэж төлөгдөх цэвэр зээл
		Цалин хөлс, НДШ	БҮ-ний бусад	Зээлийн хүү	Татаас, шилж		
Нэгдсэн төсөв	**6,298.3**	**1,339.2**	**825.0**	**425.2**	**2,461.4**	**1,228.9**	**18.7**
Улсын төсөв	5,110.7	664.7	559.0	425.2	2,434.9	1,016.0	10.7
ОН төсөв	1,413.5	664.6	405.5	0.0	122.7	212.8	7.9
НДС төсөв	1,187.3	9.0	3.3	0.0	1,175.0	0.0	0.0
ЭМДС төсөв	198.3	0.9	0.9	0.0	196.6	0.0	0.0

3. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 12.9 их наяд төгрөг байхаар баталсан бол дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2.2 их наяд төгрөгөөр буурч 10.7 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Хүснэгт № 11. Нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019 Гүйц	2020 Бат	2020 ХБГ	Зөрүү
Нийт орлого	**12,040.3**	**12,900.0**	**10,729.3**	**-2,170.7**
Тогтворжуулалтын сан	94.6	125.2	55.2	-70.0
Ирээдүйн өв сан	1,040.2	977.0	943.2	-33.8
Тэнцвэржүүлсэн орлого	**10,905.5**	**11,797.8**	**9,730.9**	**-2,066.9**
Татварын орлого	**9,813.2**	**10,656.2**	**8,847.1**	**-1,809.0**
Орлогын албан татвар	2,555.7	2,764.7	2,593.8	-170.9
НД-н орлого	2,030.5	2,402.7	1,520.2	-882.6
Хөрөнгийн албан татвар	154.4	164.8	152.7	-12.1
НӨАТ	2,486.3	2,625.9	2,278.0	-347.9
Онцгой албан татвар	863.4	953.4	734.9	-218.5
Тусгай зориулалт	16.4	15.9	16.0	0.1
Гадаад үйл ажиллагаа	790.2	874.7	771.0	-103.8
Бусад татвар	916.4	854.0	780.7	-73.3
Татварын бус орлого	**1,092.3**	**1,141.7**	**883.8**	**-257.9**

3.1.1.Уул уурхайн салбарын орлого.

Энэ оны батлагдсан төсөвт олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тонн тутамд 5,991 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 75-125 ам.доллар байхаар тооцож, уул уурхайн салбараас нийт 3,194.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолсон. Үүний 46.8 хувь буюу 1,493.5 тэрбум төгрөгийн орлогыг нүүрснээс, 36.3 хувь буюу 1,160.2 тэрбум төгрөгийн орлогыг зэсээс, бусад 16.9 хувь буюу 540.7 тэрбум төгрөгийн орлогыг бусад ашигт малтмалаас бүрдүүлэхээр тооцсон.

Гэвч дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр эхний хагас жилийн байдлаар дэлхийн эдийн засгийн идэвхжил удааширч, улмаар зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ огцом савлаж, энэ оны эхний хагаст зэсийн үнэ тонн тутамд дунджаар 5,489.6 ам.долларт хэлбэлзсэн.

Мөн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоо буурч, эхний хагас жилийн байдлаар 8.7 сая тонн нүүрс экспортолсноор нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээ болох 42.0 сая тоннд хүрч чадахгүйд хүрээд байна.

График № 17. Уул уурхайн салбарын орлого, тэрбум төгрөг



Иймд уул уурхайн салбарын орлого төлөвлөсөн хэмжээнээс 498.0 тэрбум төгрөгөөр буурч, 2,696.6 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт орлогын 26 хувийг бүрдүүлэхээр тооцлоо.

Уул уурхайн орлогын төсөөлөлд дараах хүчин зүйлсийг тооцлоо. БНХАУ-ын эдийн засаг сэргэж, аж үйлдвэрийн түрүүлэгч индекс (PMI) сүүлийн саруудад тогтмол 50 хувиас дээш гүйцэтгэлтэй гарч байгаа нь үйлдвэрлэл нэмэгдсэнийг илтгэж, улмаар уул уурхайн үйлдвэрлэлийн түүхий эдийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Мөн Монгол-Хятадын хилийн боомтуудад "Ногоон гарц"-ын түр горим хэрэгжүүлж, нүүрсний тээвэрлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллан нүүрсний экспортыг далайцтай нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

График № 18. Нүүрсний экспортын төсөөлөл, сая.тн



Түүнчлэн зэсийн гол нийлүүлэгч улсуудад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалт өндөр хэмжээнд байгаа нь зэсийн нийлүүлэлтэд доголдол үүсэх эрсдэл үүсгэж байгаа тул олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас зэсийн үнийг цаашид өснө гэж үзсэн байна. Иймд тус хүлээлтийг үндэслэн 2020 оны сүүлийн хагас жилд зэсийн үнийн дундаж

ханшийг тонн тутамд 6,400.0 ам.доллар байхаар тооцлоо.

График № 19. Зэсийн үнийн төсөөлөл, ам.доллар/тн



Эх үүсвэр: Блүүмберг терминал

3.1.2.Импортын бууралт



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэн аж ахуйн нэгж, иргэдийн хэрэглээ буурч байгаатай холбогдуулан энэ оны эхний 6 сарын байдлаар импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 15 хувь буюу 433.6 сая ам.долларoор буурч 2.5 тэрбум ам долларт хүрсэн байна. Импортын хэмжээ ийнхүү буурахад машин тоног, төхөөрөмжийн импорт 25 хувиар, барилгын материалын импорт 9 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 25 хувиар тус тус буурсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

График № 20. Эхний 6 сарын импорт, сая ам.доллар



Энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр импортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 16 гаруй хувиар буурч 5.6 тэрбум ам долларт хүрэх төлөвтэй байна.

Үүнтэй холбогдуулан гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлого 471.7 тэрбум төгрөг буюу 13.5 хувиар буурах хандлагатай байна.

3.1.4. Ирээдүйн өв сан

Ирээдүйн өв сангийн гол эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь болон ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг юм.

Хүснэгт № 12. Ирээдүйн өв сангийн орлого, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 он	2019 он	2020.06.30	2020 бат	2020 ХБГ
Нийт орлого	620.7	1,040.2	246.5	977.0	943.2
Ногдол	32.1	152.7	-	791.9	758.2
АМНАТ	588.6	887.5	246.5	155.0	155.0
Хүүгийн орлого	-	-	-	30.0	30.0

Ирээдүйн өв санд 2020 онд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 155.0 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 791.9 тэрбум төгрөг, нийт 976.9 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар тооцож баталсан боловч дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн идэвхжил суларч, улмаар дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ огцом уналтад орсон

нь тус санд төвлөрөх орлогын бууралтад нөлөөлөхөөр байна.

Ирээдүйн өв санд энэ онд батлагдсан хэмжээнээс 33.8 тэрбум төгрөгөөр бага буюу 943.2 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар байна.

4. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал нь улс орнуудад урьдчилан тооцоолох боломжгүй хүндрэлийг бий болголоо. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр өнөөгийн[2] байдлаар нийт 20.8 сая хүн халдвар авч, 747.5 мянган хүн нас баржээ. Өргөн хүрээг хамарсан хөл хорионы дэглэм, хилийн хязгаарлалт зэрэг онцгой нөхцөл байдлаас үүдэн олон сая хүмүүсийн орлого, амьжиргаа, ажлын байр, амьдралын хэв маяг тасалдсаныг олон улсын байгууллагууд ч мэдээлж байна.

Дэлхийн ихэнх орнууд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалтаас үүдэлтэй эдийн засгийн уналтыг сааруулах, иргэд, бизнес эрхлэгчдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалахад чиглэсэн төсөв мөнгөний бодлогыг хэрэгжүүлж багц арга хэмжээнүүдийг шат дараатай хэрэгжүүлж байна. Ингэснээр төсвийн зарлага огцом нэмэгдэж, үүнийг төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэж байна.

Монгол Улсын Засгийн газраас өөрсдийн нөхцөл байдал, боломждоо тааруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж ирлээ. Түүнчлэн, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас улс, орнуудын эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн зах зээл дахь гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ, эрэлт буурч байгаа боловч Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргаа, орлогыг дэмжих, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, ажлын байрыг хамгаалах, эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, дунд хугацаанд эрчимжүүлэх боломжтой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Энэ оны 2 дугаар сараас эхлэн 10 дугаар сарыг хүртэл коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөөд байна. Ингэснээр 20.2 сая ширхэг амны хаалт, 6.2 сая ширхэг хамгаалалтын хувцас, хэрэгсэл, 8,341 ширхэг зайнаас халуун хэмжигч, 484 кг оношлуур, 15,421 ширхэг утлагын аппарат, 93,702 кг ариутгагч бэлдмэл болон бусад нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг 4.3 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлж цар тахлын үед ашиглагдах эм эмнэлгийн хэрэгслийн

[2] 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар

хомсдол, үнийн хэт өсөлт үүсэхээс урьдчилан сэргийлж чадлаа.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис худалдан авах, эмч эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн хөлсөнд шаардагдах 6.5 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлсэн ба цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад зориулж 3.9 сая ширхэг хувийн хамгаалах хэрэгсэл, 33 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 18,700 ширхэг нарийн мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, 72 ширхэг амьсгалын аппарат, 60 ширхэг утлагын аппарат, 70 ширхэг хүчилтөрөгч өтгөрүүлэгч, 105 ширхэг пульсоксиметр, 292 ширхэг бусад төхөөрөмж аваад байна.

3. Улсын төсвийн эх үүсвэрээс гадна олон улсын хандивлагч байгууллагуудаас өгсөн тусламжийг цар тахлын эсрэг тэмцэхэд зориулж байна. Азийн хөгжлийн банкны 90.2 тэрбум төгрөг, Дэлхийн банкны 81.3 тэрбум төгрөг, бусад олон улсын байгууллагын 4.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр нэн шаардлагатай нэмэлт эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг шийдвэрлээд байна.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ИРГЭДИЙН ОРЛОГЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Энэ оны 4 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарыг хүртэл хугацаанд хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэдийн цалин хөлснөөс хувь хүний орлогын албан татвар авахгүй, 6 сарын хугацаанд бүрэн чөлөөлсөн. Үүний үр дүнд хувийн хэвшилд ажиллаж байгаа 700 мянга гаруй иргэний 87.5 тэрбум төгрөгийн орлого иргэдийн гарт үлдсэн байна.

2. Энэ оноос эхлэн нэмэгдсэн өртгийн албан татварын иргэдийн буцаан олголтыг улирал тутам олгож байна. Эхний улиралд 870,143 иргэнд 35.6 тэрбум төгрөгийг, хоёрдугаар улиралд 901,615 иргэнд 38.2 тэрбум төгрөг, нийт 73.8 тэрбум төгрөгийг буцаан олгожээ.

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан 6.9 мянган аж ахуйн нэгжийн 73,000 орчим ажилтанд сард 200.000 төгрөг буюу нийт 25.2 тэрбум төгрөгийг олгоод байна.

4. Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн зардлын хэмнэлтээс 18 хүртэлх насны бүх хүүхдэд сар бүр 10.0 мянган төгрөгийг гурван сарын хугацаанд олгоход шаардагдах 34.9 тэрбум төгрөгийг 4, 5, 6 дугаар саруудад санхүүжүүлсэн.

5. 18 хүртэлх насны хүүхэд бүрд олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 1,191,099 хүүхдэд 4, 5, 6, 7 дугаар саруудад тус бүр 100,000 төгрөгийн тэтгэмжийг олгоход сард

дунджаар 117.1 тэрбум төгрөг зарцуулаад байна.

6. Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс сар бүр нэг хүүхдэд 16,000 төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32,000 төгрөг, нийт 242,992 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэгийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр олгоход 8.8 тэрбум төгрөг, эхний хагас жилийн байдлаар нийт 27.5 тэрбум төгрөг зарцуулаад байна.

7. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 67.3 мянган иргэнд, үүнээс 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй 10.6 мянган хүүхдэд нийт 20.0 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгоод байна.

8. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний статистикийн хорооны 2019 оны мал тооллогын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн 1 кг ноолуур тутамд 20,000 төгрөгөөр тооцож, нийт 203,441 малчин, мал бүхий иргэдэд 175.0 тэрбум төгрөгийн урамшууллыг төрийн санг дамжуулан олгоод байна.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Энэ оны 4 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарыг хүртэл жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг 6 сарын хугацаанд орлогын албан татвараас чөлөөлсөн. Өнөөгийн байдлаар 105.0 мянга гаруй аж ахуйн нэгжийг 20.0 орчим тэрбум төгрөгийн татвараас чөлөөлж, бизнес эрхлэгчдийг дэмжсэн байна.

2. Энэ оны 2 дугаар сараас эхлэн 9 дүгээр сарыг хүртэл татварын алданги, торгуулийг 7 сарын хугацаанд чөлөөлсөн байна.

3. Энэ оны 2 дугаар сараас эхлэн 9 дүгээр сарыг хүртэл түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжид бууруулсан дүнгийн хэмжээгээр 7 сарын хугацаанд түрээсийн орлогод ногдох татварын хөнгөлөлт үзүүлсэн. Өнөөгийн байдлаар томоохон зах, худалдааны төвүүд түрээсийн төлбөрөө бууруулж нийт 10.0 орчим тэрбум төгрөгийг татварын хөнгөлөлтөд хамрагдсан байна. Ингэснээр 1,000.0 орчим аж ахуйн нэгж, 25.0 мянга гаруй худалдаа эрхлэгчдийн түрээсийн төлбөр буурчээ.

4. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хамаарах нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд оногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлөх арга хэмжээний хүрээнд нийт 12,783 аж ахуйн нэгжийг төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлд тооцох алданги, торгуулиас чөлөөлөөд байна.

5. Энэ оны 4 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарыг дуустал аж ахуйн нэгж, сайн дурын даатгуулагчдыг 6 сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээс бүрэн чөлөөлсөн. Уг арга хэмжээнд нийт 38.4 мянган аж ахуйн нэгжийн 401.8 мянган

даатгуулагч, 144.3 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж 4, 5, 6 дугаар саруудад нийт 271.0 тэрбум төгрөгийн чөлөөлөлт хийгээд байна.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Хил дээрх ариутгал, халдваргүйжүүлэлтийг нэмэгдүүлж, тээвэрлэлт хийж байгаа жолооч нарын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ нүүрс, газрын тос болон ашигт малтмалын бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Ингэснээр 2 дугаар сард өдөрт дунджаар 55 нүүрс ачсан машин гардаг байсан бол өнөөдрийн байдлаар өдөрт дунджаар 1,012 нүүрс ачсан машин гарч байгаа бөгөөд нүүрсний экспорт тогтмол нэмэгдэж байна.

2. Энэ оны 2 дугаар сараас эхлэн 6 дугаар сарыг дуустал импортын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Ингэснээр 110 гаруй аж ахуйн нэгжийн импортолсон 88.6 сая кг улаан буудай, 27.2 сая кг хүнсний будаа, 11.7 сая литр ургамлын тос, 27.5 сая кг элсэн чихрийг 24.0 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлж дотоодын зах зээлд борлуулж буй гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний тогтвортой хадгалж чадлаа.

3. Эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд хөнгөлөлттэй зээл, тусламжийн хямд эх үүсвэр ашиглах зорилт тавин Засгийн газраас нийт 1,077.1 сая ам долларын санхүүжилтийг оруулж ирэх зорилтыг тавин ажиллаж бөгөөд одоогийн байдлаар үүний 870.5 сая ам долларын эх үүсвэрийг шийдвэрлээд байна.

4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэлийн үед төсвийн мөнгөн хөрөнгийн удирдлага, төлбөр гүйцэтгэх бэлэн байдлыг хангах зорилгоор төсвийн зарлагыг 2020 оны 2 дугаар сараас эхлэн эрүүл мэнд зэрэг онцгой салбаруудын бүх урсгал зардал, түүнчлэн бүх шатны төсөвт байгууллагын цалин, тогтмол зардал, тэтгэвэр, тэтгэмжийг тэргүүн ээлжид санхүүжүүлэхээр, бусад зардлыг ач холбогдол, нэн шаардлагатай байдлыг нь харгалзан үзэж санхүүжүүлэхээр, харин гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зэрэг зардлын санхүүжилтийг түр хугацаагаар зогсоогоод байна.

5. Хүүхэд бүрт 6 сарын турш сар бүр 100.0 мянган төгрөг олгох, малчдад ноолуурын урамшуулал олгох зэрэг арга хэмжээг эрүүл мэнд, цагдаа, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, хилийн мэргэжлийн хяналтын байгууллага зэрэг байгууллагаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн төсөвт зохицуулалт хийх замаар санхүүжүүлсэн. Үүнд: нийт ТЕЗ-ийн батлагдсан төсвийн хангамж, бараа материалын зардлыг 2,348.9 сая төгрөгөөр, норматив зардлыг 4,177.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 618.8 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,905.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 68,531.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад

зардлыг 12,447.0 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр, татаасны зардлыг 11,184.9 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 571,924.5 сая төгрөгөөр тус тус бууруулах зохицуулалтыг хийж хүүхдийн мөнгөний эх үүсвэрийг 592,900.0 сая төгрөгөөр, малчдад олгох ноолуурын урамшууллыг 175.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотойгоор 2020 оны 2 дугаар сараас 10 дугаар сарын дуустал дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнээс нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) болон түүний алданги, торгуулиас чөлөөлөх арга хэмжээнд 870.0 тэрбум төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөг болгон нэмэгдүүлэхэд 552.2 тэрбум төгрөг зарцуулж байгаа нь дийлэнх хэсгийг эзэлж байна.

Хүснэгт № 13. КОВИД-19-тай холбоотой 2020 оны 2 дугаар сараас 10 дугаар сарын дуустал авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэрбум төгрөг

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Дүн
Оношлуур, эм эмнэлгийн хэрэгслийг гаалийн болон НӨАТ-с чөлөөлөх	4.3
НДШ болон түүний алданги, торгуулиас чөлөөлсөн	870.0
ААН-ийг ХХОАТ-с чөлөөлсөн	175.0
104 мян. ААН ААНОАТ-с чөлөөлсөн	45.0
Түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулсан ААН-д түрээсийн орлогод ногдох татвараас чөлөөлсөн	20.0
Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мян. төгрөг болгон нэмэгдүүлсэн	552.2
Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн	35.1
Хүнсний талоны тарифыг нэмэгдүүлсэн	9.5
Ноолуурын урамшуулал олгож, малчдын орлогыг дэмжсэн	175.0
НИЙТ	**1,886.1**

5.НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ

5.1. Төсөвт тодотгол хийх үндэслэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2020 оны эхний 6 сарын байдлаар 4,358.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1,212.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас ийнхүү эдийн засгийн өсөлт саарч, улмаар оны эцэст төсвийн орлого буурах нөхцөл байдал үүсээд байгаа тул Засгийн газраас эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээнүүдийг он дуустал үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, мөн УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийг тусган төсвийн тодотголын төслийг боловсруулаа.

5.2. Төсвийн тодотголд баримтлах үндсэн зарчмууд

Төсвийн тодотгол хийх шаардлага, үндэслэлд суурилан дараах зарчмыг баримтлан тодотголын төслийг боловсруулаа:

01 ***Иргэд, аж ахуй нэгжийг үргэлжлүүлэн дэмжинэ.***

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн зарим арга хэмжээг үргэлжлүүлнэ.

02 ***Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангана.***

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай санхүүжилтийг тэргүүн ээлжид шийдвэрлэнэ.

03 ***Экспортыг нэмэгдүүлнэ.***

Экспортыг далайцтай нэмэгдүүлэх бүхий л арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай хэрэгжүүлнэ.

04 ***Цахим шилжилтийг хурдасгана.***

Иргэд, бизнес эрхлэгчдэд үзүүлэх төрийн үйлчилгээ, бүх төрлийн тусгай зөвшөөрлийг цахим болгох замаар төрийн үйл ажиллагааг хүнд сурталгүй, шуурхай болгоно.

05 ***Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлнэ.***

- Гэрээ байгуулаагүй болон үр ашиггүй төслийг хасна;
- Дараа он руу шилжих болон ажлын гүйцэтгэл удаашралтай төслүүдийн санхүүжилтийг бууруулна.

5.3. Төсвийн тодотголоор авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Дээрх зарчмуудыг баримтлан дараах арга хэмжээнүүдийг төсвийн тодотголоор шийдвэрлэхээр уг хуулийн төсөлд тусгалаа.

5.3.1. Иргэд аж ахуй нэгжийг үргэлжлүүлэн дэмжих чиглэлээр:

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хэмжээг нэмэгдүүлснийг он дуустал хугацаанд үргэлжлүүлэн олгоно. Нийт 1,250.0 мянган хүүхдэд 2020 оныг дуустал 3 сарын хугацаанд Хүүхдийн мөнгөн тэтгэмж 100.0 мянган төгрөгийг үргэлжлүүлэн олгоход нийтдээ **300.0 тэрбум** төгрөг зарцуулна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж: Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 288.0 мянган төгрөг олгож байгаа арга хэмжээг оны сүүлийн гурван сард үргэлжлүүлэн олгох ба нийтдээ 73.3 мянган хүн хамрагдаж **22.0 тэрбум** төгрөг нэмж зарцуулна.

Хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг 2 дахин нэмэгдүүлж олгоно. Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн насанд хүрсэн иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг 2 дахин нэмэгдүүлж байгаа арга хэмжээг үргэлжлүүлэн олгоход нийт 124.0 мянган иргэн хамрагдаж **6.0 тэрбум** төгрөг нэмж зарцуулна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх болон хөнгөлнө. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж байгаа ажил олгогч болон даатгуулагчийн төлөх Нийгмийн даатгалын шимтгэлийг "тэглэсэн" арга хэмжээ 2020 оны 10 дугаар сарын 1-ээр дуусгавар болно. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэл цаашид үргэлжлэх төлөвтэй байгааг харгалзан шимтгэлийн "чөлөөлөлт"-ийн арга хэмжээг 2020 оны 10-12 дугаар саруудад шимтгэлийн "хөнгөлөлт" байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр тооцов. Ингэхдээ шимтгэл "тэглэх" арга хэмжээнд хамрагдсан ААН, даатгуулагчийн төлөх шимтгэлийг ажил олгогч 5%, даатгуулагч 5% байхаар тооцсон болно.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар анх 2,291.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон ба коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас аж ахуйн нэгж, даатгуулагчийн шимтгэлийг тэглэх шийдвэр, мөн дээр дурдсан шимтгэлийн хөнгөлөлтийг хэрэгжүүлснээр Нийгмийн даатгалын санд төвлөрөх шимтгэлийн хэмжээ оны эцэст 880.0 орчим тэрбум төгрөгөөр буурах тооцоотой байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг он дуустал үргэлжлүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлнө. Энэ оны 4 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарыг хүртэл жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг 6 сарын хугацаанд орлогын албан татвараас чөлөөлсөн. Энэхүү татварын чөлөөлөлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэлт байдлыг харгалзан 2020 он дуустал үргэлжлүүлэхээр тооцлоо.

Түрээсийн орлогын татварын хөнгөлөлт үзүүлнэ. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас энэ оны 2 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл хугацаанд түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод ногдуулах татварыг хөнгөлсөн арга хэмжээг 2020 оныг дуустал хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба ингэснээр 1,000.0 орчим ААН, 25.0 мянган худалдаа эрхлэгчдийн түрээсийн төлбөр буурах боломжтой.

5.3.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангах чиглэлээр

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх, улирлын томуугийн болон коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцин худалдан авах, иргэдийн эрүүл мэнд, дархлааг дэмжих төв байгуулах, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай нүүр тулан ажиллаж буй эмч, ажилчдад илүү цаг, ар гэрт дэмжлэг олгох болон бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхэд 118.6 тэрбум төгрөг, эрүүл мэндээс бусад салбарын цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын хувцас, хамгаалах хэрэгсэлд зориулж нийт 6.2 тэрбум төгрөг, Засгийн газрын нөөц санг дээрх зориулалтаар 40.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр тусгалаа.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр төсвийн орлого тодорхой хэмжээнд буурч байгаа боловч цар тахлын улмаас үүссэн хүндрэлээс иргэд, аж ахуйн нэгжээ хамгаалж чадсан, цагаа олсон арга хэмжээнүүдээс хамгийн хүртээмж өндөртэй, өргөн хүрээг хамарсан зарим арга хэмжээг энэ оныг дуустал хэрэгжүүлж ирээдүйд үүсэх томоохон эрсдэлийг саармагжуулахаар төлөвлөж байна. Үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд нийт 673.7 тэрбум төгрөг зарцуулагдах ба арга хэмжээний задаргааг авч үзвэл:

Хүснэгт № 14. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотойгоор он дуустал үргэлжлүүлэх арга хэмжээ, тэрбум төгрөг

	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв
%	Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах	144.4
	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөг, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх арга хэмжээг он дуустал үргэлжлүүлэн олгох	322.0
	Хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг насанд хүрсэн иргэнд 2 дахин нэмэгдүүлж олгох арга хэмжээг он дуустал үргэлжлүүлэх	6.0
	Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах	118.6
	Мэргэжлийн хяналт, онцгой байдал, цагдаа, хил хамгаалах, гааль г.м бусад салбарын бэлэн байдлыг хангах	6.2
	Эрсдэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх	40.0
	Оношлуур, эм эмнэлгийн хэрэгслийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх	14.0
	Жилийн 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-ийг ААНОАТ-аас үргэлжлүүлэн чөлөөлөх	15.0
	Түрээсийн төлбөрөө бууруулсан ААН-ийн түрээсийн орлогод ногдуулах татварыг үргэлжлүүлэн хөнгөлөх	7.5
	НИЙТ	**673.7**

5.3.3. Экспортыг далайцтай нэмэгдүүлэх, төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр авах арга хэмжээ:

Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн, газрын тосны экспортыг нэмэгдүүлнэ. Засгийн газраас нүүрс, газрын тос болон ашигт малтмалын бусад бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр боломжит бүх арга хэмжээг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлттэй уялдуулан үе шаттай авч хэрэгжүүлж байна.

БНХАУ-д коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлт эрчимтэй нэмэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 78 дугаар тогтоолоор экспортын тээвэрлэлт хийж байгаа иргэд, жолооч нарт коронавируст халдвар (КОВИД-19) дамжихаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлсэн. Тухайлбал, экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах заавар, журмыг боловсруулан аж ахуйн нэгж байгууллагуудаар мөрдүүлэх, тээвэрлэлт хийж байгаа жолооч нарын хоол хүнсний хангамж, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авч ажилласан болно.

Дээрх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд дотоодод коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлт үүсэхээс урьдчилан сэргийлж, экспортын биет хэмжээг тогтмол нэмэгдүүлж байна. Тодруулбал, энэ оны хоёрдугаар сард өдөрт дунджаар 55 нүүрс ачсан автомашин гарч байсан бол 7 дугаар сарын байдлаар өдөрт гарах нүүрс ачсан автомашины тоо 1,012 хүрч, өмнөх оны мөн үеийн түвшинд хүрээд байна.

Энэ оны 5 дугаар сараас эхлэн БНХАУ-д цар тахлын дэгдэлт намжиж, манай улстай хиллэж буй бүс нутагт халдварын тохиолдол харьцангуй бага байгаатай холбогдуулан хоёр орны хооронд худалдаа, тээврийн үйл ажиллагааг сэргээн нэмэгдүүлэх, ачаа тээвэрлэлтэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Монгол-Хятадын хилийн боомтуудад “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Энэхүү түр журмын хүрээнд Замын-Үүд – Эрээн, Баянхошуу – Өвдөг, Гашуунсухайт – Ганцмод, Шивээхүрэн – Сэхээ, Бичигт – Зүүнхатавч, Бургастай – Лаоемяо, Булган – Такашикен зэрэг боомтуудаар тээвэр хийж байгаа жолооч нарт хилийн цаана хоноглох боломжийг бүрдүүлж, хилээр нэвтрэх цагийг уртасгаснаар 2020 оны хоёрдугаар хагас жилд экспортын хэмжээг далайцтай нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн, экспортын нийлүүлэлт доголдож болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газраас Эрдэнэт, Оюутолгой, Таван толгой, Нарийн сухайт, Тамсаг гэх мэт томоохон орд газруудад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тос экспортлогч аж ахуйн нэгжүүдийн халдвар, хамгаалалтын дэглэмд онцгой анхаарч ажиллана.

Цахим бүртгэлийг сайжруулж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах, хүнд суртлыг бууруулах зорилгоор цахим шилжилтийг

эрчимжүүлэх ажлыг Засгийн газар онцгой анхаарч байна. Цахим шилжилтийн хүрээнд Е-баримт, Татварын удирдлагын нэгдсэн системийг хөгжүүлж, гааль, татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулах арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх замаар татварын суурийг нэмэгдүүлнэ.

Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байгаа үед Засгийн газар экспортыг далайцтай нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд борлуулалт нь нэмэгдэх төрийн өмчит томоохон аж ахуйн нэгжүүдээс татварын урьдчилгаа авна. Гадаад зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ өсөж, энэ хэмжээнд цаашид тогтвортой байх төсөөллийг олон улсын санхүүгийн байгууллагууд хийж байна. Энэ нөхцөл байдалд Засгийн газар экспортыг нэмэгдүүлэх боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлж, уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ гол экспортлогч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэс Таван толгой" ХК зэрэг төрийн өмчит томоохон аж ахуйн нэгжүүдээс татварын урьдчилгаа авах замаар төсвийн орлого дайчлах нэг удаагийн онцгой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тооцож байна.

5.3.4. Цахим шилжилтийг хурдасгах, урсгал зардлыг хэмнэх чиглэлээр:

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг хэмнэх чиглэлээр: Төсвийн зардлын 2020 оны үлдэх хугацааны санхүүжилтийг ач холбогдлоор нь эрэмбэлж олгоно. Түүнчлэн төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсөвт байгууллагын тэвчиж болох зарим зардал, арга хэмжээг бүрэн болон хэсэгчлэн зогсоох замаар **118.2** тэрбум төгрөгийг хэмнэнэ.

Хүснэгт № 15. Урсгал зардлыг санхүүжүүлэх эрэмбэ (сая төгрөг)

Санхүү-жүүлэх эрэмбэ	Чиглэл	Нийт
Тэргүүн ээлж I	Эрүүл мэнд,	525.2
	цагдаа, хил, онцгой, гааль, татвар, мэргэжлийн хяналт	300.2
Тэргүүн ээлж II	Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, тэтгэвэр, тэтгэмж	3,583.9
Тэвчиж болох	Бичиг хэрэг, тавилга эд хогшил, томилолт, татаас урсгал шилжүүлэг, БАУ-ний бусад	118,200.0

Цаашид технологийн дэвшилтэт шийдэлд суурилсан өөрчлөлт хийх замаар дунд болон урт хугацаанд зардлын өсөлтийг бууруулах зорилт тавьж байгаа бөгөөд дараах чиглэлээр өөрчлөлт хийхээр төлөвлөж байна:

Дотоод албан томилолтыг салбарын онцлогийг харгалзан ялгавартай тогтооно. Төсвийн байгууллагуудыг захиргааны, үйлчилгээний, аюулгүй байдлыг хангах, хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж байгаа эсэхээс нь хамааруулж дотоод албан томилолтоор ажиллах хэрэгцээ, шаардлага, давтамжийг нь харгалзсан ялгавартай норматив тогтоож мөрдүүлнэ.

Төсвийн байгууллагыг халаалтын тоолуурт шилжүүлнэ. Эрчим хүчний зохицуулах хорооны судалгаагаар орон нутаг дахь 4,235 төрийн байгууллагад дулааны тоолуур суурилуулах боломжтой гэж гарсан байна.

Хүснэгт № 16. Дулааны тоолуур суурилуулах орон нутаг дах байгууллагын тоо

Аймаг	Аймгийн төвд	Сумд	НИЙТ
Архангай	53	158	211
Баян-Өлгий	66	124	190
Баянхонгор	30	187	217
Булган	46	173	219
Говь-Алтай	55	168	223
Говьсүмбэр	37	10	47
Дархан-уул	86	37	123
Дорноговь	57	149	206
Дорнод	48	139	187
Дундговь	36	159	195
Завхан	53	282	335
Орхон	97	5	102
Өвөрхангай	37	209	246
Өмнөговь	16	142	158
Сүхбаатар	32	132	164
Сэлэнгэ	43	189	232
Төв	23	182	205
Увс	56	145	201
Ховд	41	157	198
Хөвсгөл	63	297	360
Хэнтий	23	193	216
НИЙТ	**998**	**3,237**	**4,235**

Төв аймгийн зарим байгууллагуудад суурилуулсан тоолуурын туршилтын үр дүнд халаалтын зардлыг 50 хувь хэмнэх боломжтой ба барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах нь цаашид зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

Төсвийн зарлагын шинэчлэл, цахим шилжилтийг хурдасгах чиглэлээр:

Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор төрийн үйлчилгээний цахим шилжилтийг түргэтгэх зорилт тавьж байна. Төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн үйлчилгээний байгууллагад хүн олноор цуглуулахгүй байх, төрийн үйлчилгээний хүнд суртал, авлигыг арилгах, иргэнд хүргэх үйлчилгээний хурд нэмэгдэх эерэг үр дагавартай юм.

Хүснэгт № 17. Богино хугацаанд цахим үйлчилгээнд хамруулах салбар, чиглэл

Цахим систем	Хамрах хүрээ
Эрүүл мэндийн цахим нэгдсэн сүлжээ E-Health (ЭМДЕГ)	Төрийн хувийн эмнэлэг, Эмийн сан, Иргэн, ЭМД, ЭМЯ
Нийгмийн халамжийн цахим сүлжээ E-Care (ХНХЯ)	17 төрлийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлт
Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (Сангийн яам)	Төсвийн бүх байгууллага
Хүний нөөцийн удирдлагын систем (Төрийн албаны зөвлөл)	Төсвийн бүх байгууллага
ХАА-н татаас урамшуулын цахим хяналт (Сангийн яам)	ХАА бүтээгдэхүүн бэлтгэсэн иргэн, түүнийг худалдан авсан ААН
Цахим сургалт, хурал, семинар (ТЕЗ нар)	Төсвийн бүх байгууллага
Цахим өргөдөл, гомдол, хүсэлт (ТЕЗ нар)	Төсвийн бүх байгууллага

Эрүүл мэндийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, гүйцэтгэлээр нь санхүжүүлнэ. Цахим системд шилжсэнээр 1/ хувийн эмнэлэгт хэвтсэн даатгуулагч ЭМД ашиглан үйлчилгээ авах; 2/ эрүүл мэндийн байгууллагыг хэвтүүлсэн хүний тоогоор бус харин эмчлэн эдгэрүүлсэн хүний тоогоор санхүжүүлэх; 3/ эмийн санд ЭМД-аар олгодог хөнгөлөлттэй эмийн дараалал арилах; 4/ иргэн, бүх шатны эмнэлэг, эмийн сан, ЭМД-ын байгууллага, ЭМЯ-г хооронд нь холбосон нэгдсэн цахим сүлжээ бий болох; 5/ санхүүжилт болон хяналтын нэгдсэн сүлжээ бий болох зэрэг ач холбогдолтой юм.

Нийгмийн халамжийн цахим системийг нэвтрүүлж хамрах хүрээг оновчтой болгож давхардлыг арилгах зорилт тавьж байна. Халамжийн үйлчилгээг авах өрх, иргэнийг

тодорхойлж байгаа одоогийн аргачлалыг өөрчилж, тухайн өрх, иргэний хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн цогц үйлчилгээг нэвтрүүлэх

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, (улаан буудай, ноос ноолуур, арьс шир, мах, сүү) үйлдвэрлэлийг дэмжих татаас урамшууллыг үндэсний үйлдвэрлэлд үндэсний үйлдвэрт тушаасан бүтээгдэхүүний төлбөрийн баримтыг үндэслэн цахимаар хянаж олгоно. Ингэснээр ХАА-н бүтээгдэхүүн бэлтгэж ААН-д нийлүүлсэн иргэн холбогдох яам, харьяа салбар, нэгжүүдэд цаасаар баримт материал бүрдүүлэх, биеэр очих шаардлагагүй болно.

"Төрийн албаны цалингийн нэгдсэн систем"-ийг бүрэн ашиглалтад оруулна. Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолын дагуу Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын систем (ХНУС)-д суурилсан "Төрийн албаны цалингийн нэгдсэн систем"-(ТАЦНС)ийг 2020 оны 5 дугаар сараас эхлэн улсын хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлж эхлээд байна. Эхний шатанд 21 аймаг дахь улсын болон орон нутгийн төсвийн нийт 3,270 байгууллагаас 1,100 байгууллагын үндсэн болон гэрээт ажилтнуудын албан тушаалын болон цалин хөлсний мэдээллийг ХНУС-д шинэчлэн оруулсны үндсэн дээр 5 дугаар сарын цалин хөлсийг ТАНЦС-д тооцоолж бодит цалингийн төсөвтэй нь тулгалт хийж дуусгаад байна. Ирэх 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс ТАЦНС-д бүх шатны төсвийн байгууллагыг бүрэн хамруулахаар ажиллаж байна.

Бусад чиглэлээр: Төрийн байгууллагын хурал, семинар, сургалтыг цаашид цахимаар явуулж холбогдох зардлыг бууруулна. Төрийн байгууллагад иргэдээс тавьсан өргөдөл гомдол шийдвэрлэх процессыг цахимжуулна.

5.3.5. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2020 онд улсын төсвөөс 680.0 тэрбум, Эрүүл мэндийн даатгал(ЭМД)-ын сангаас 506.0 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн өнөөгийн тогтолцооны үр дагавар нь улсын эмнэлгүүдийн ачаалал, хүлээгдэл, иргэний бухимдлыг бий болгож, хувийн эмнэлгээс үйлчилгээ авсан орлого багатай иргэд санхүүгийн эрсдэлд орж байна. Улсын эмнэлгүүдийн эмч, ажилчдын ажлын ачаалал, гүйцэтгэлтэй уялдсан цалин, урамшуллын механизмгүйгээс иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх сонирхлыг бууруулж байна. Түүнчлэн ЭМД-ын сангаас зөвхөн өрх, сумын эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт олгож байгаа нь өрхийн эмчийн ачааллыг нэмэгдүүлж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд сүүлийн жилүүдэд холбогдох судалгаа, шинжилгээ хийж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлага, арга замуудыг тодорхойлсон бөгөөд ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, санхүүгийн бэрхшээлийг арилгахад чиглэсэн тогтолцооны шинэчлэлийг нэн даруй хийх нь зүйтэй гэж үзсэн болно.

Иргэд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас өвчин, эмгэгийн төрлөөс үл хамааран шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, шуурхай авдаг болох зорилгоор эрүүл мэндийн салбарт хуваарилах санхүүжилтийг нэг худалдан авагчийн зарчмаар буюу эрүүл мэндийн даатгалын байгууллага улсын төсвөөс олгож байгаа санхүүжилтийг хуваарилдаг байхаар тооцож Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төсөл боловсруулав. Улсын төсвийн одоогийн санхүүжилтийг өвчин, эмгэгийн нэр төрөл, тусламж, үйлчилгээний өртөг, тоо хэмжээнд үндэслэн тооцож эрүүл мэндийн даатгалын санд жил бүр шилжүүлснээр иргэн эрүүл мэндийн даатгалаараа эмнэлгийн бүх төрлийн тусламж, үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй авах, бүх шатлалын эмнэлгийн эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт авах боломж бүрдэнэ.

5.3.6. Бусад:

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн зарим заалтын хэрэгжилтийг хойшлуулна. Уг хууль 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр батлагдаж сургуулийн орчныг сургуульд эзэмшүүлсэн газар түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газрыг хамааруулж, ундааны зүйлс, амттан зууш, боловсруулсан, хагас боловсруулсан хүнс, түргэн хоол гэсэн 3 бүлэгтэй, нийт 20 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглохоор тусгасан. Одоогоор ерөнхий боловсролын 781 сургуулийн орчинд 3043 хүнсний худалдаа, үйлчилгээний газар үйл ажиллагаа явуулж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасныг үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг дагаж мөрдөх хугацааг түр хугацаагаар хойшлуулах шаардлага үүсээд байна.

Түүнчлэн мөн хуулийн 11.1.1-д төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын байр, талбай, тоног төхөөрөмжийг түрээслүүлэх, сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнээс бусад зориулалтаар ашиглахыг хориглохоор хуульчилсан. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 662 сургуулиас орон нутагт байрлах 485 сургуулийн 37 буюу 7.6 хувь, нийслэлийн 140 сургуулийн 122 буюу 87 хувь нь аж ахуй нэгжтэй түрээсийн гэрээ байгуулан үдийн цайны үйлчилгээг үзүүлж байна.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийг танхимын хэлбэрээр хичээллүүлэхээр болсонтой холбогдуулан суралцагчдад үдийн цайг үргэлжлүүлэн өгнө.

Дээрх асуудлыг шийдвэрлэх төсөв 2020 оны улсын төсөвт тусгагдаагүй тул 662 ерөнхий сургуулийн сургуулийн 342.6 мянган суралцагчдад үдийн цайны үйлчилгээг үзүүлэх боломжгүй нөхцөл үүсээд байгаатай холбогдуулан уг хуулийн 11.1.1 дэх заалтыг дагаж мөрдөх хугацааг хойшлуулах шаардлагатай байна.

Жендерийн үндэсний хорооны харьяаллыг шилжүүлнэ. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 17.1, 17.2-д "Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудал хамаарна", "Монгол Улсын Ерөнхий сайд Жендерийн үндэсний хороог тэргүүлж, түүний үйл ажиллагааг удирдлагаар хангана." гэж заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дах хэсгийн 8-д Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд "жендерийн хөгжлийн асуудал" гэж заасантай зөрчилдөж байна. Мөн "Монгол Улс ахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолын 4.1-д Жендерийн үндэсний хорооны ажлын албыг бие даасан бүтэцтэйгээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий сайдад чиглэл өгснийг үндэслэн Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

5.3.7. Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлэх чиглэлээр:

Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар **1,828.9** тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий **1427** төсөл, арга хэмжээ, концессын "Барих-Шилжүүлэх" төрлөөр гэрээ байгуулсан **11** төслийн гэрээний эргэн төлөлтийн төлбөрт **323.6** тэрбум төгрөг тусгагдаж, нийт **2,152.5** тэрбум төгрөгийн **1438** төсөл, арга хэмжээ батлагдсан.

Улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын **35.8** хувь буюу **1,010.5** тэрбум төгрөгийн **511** төсөл нь он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ бол **68.4** хувь нь **818.4** тэрбум төгрөгийн **916** төсөл нь 2020 онд шинээр хэрэгжих төслүүд юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл *2020 оны 8 дугаар сарын 10-ны* өдрийн байдлаар **663.1** тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл **30.8** хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тодотголыг дараах хоёр зарчмыг баримтлан боловсруулаа. Үүнд:

1. Гэрээ байгуулаагүй төслүүд, мөн тэвчиж болох төслүүдийн санхүүжилтийг хасах;

2. Дараа он руу үргэлжлэх төслүүд болон ажлын гүйцэтгэлтэй уялдуулан, удаашралтай төслүүдийн санхүүжилтийг бууруулж 2021 он руу хойшлуулах.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх нийт 916 төсөл, арга хэмжээнээс 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 663 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан, үлдсэн 253 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулаагүй байна. Гэрээ байгуулсан 663 шинэ төсөл, арга хэмжээнд нийт **117.5** тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Хүснэгт № 18. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2020.08.10-ны өдрийн байдлаар, сая төгрөг

Дэс дугаар	ТЕЗ	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	2020.08.10-ны байдлаар		
					Нийт гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Үлдэгдэл санхүүжилт
I	Монгол Улсын Их Хурлын дарга	2	2,560.8	2,560.8	217.7	8.50%	2,343.1
II	Монгол Улсын Ерөнхий сайд	8	36,159.0	23,459.0	15,586.4	66.44%	7,872.6
III	Монгол Улсын Шадар сайд	11	40,139.9	9,934.9	6,359.7	64.01%	3,575.2
IV	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	76	62,761.9	32,529.5	10,595.3	32.57%	21,934.2
V	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	30	44,276.8	25,426.8	4,107.9	16.16%	21,318.9
VI	Батлан хамгаалахын сайд	6	23,126.0	11,080.0	2,986.1	26.95%	8,093.9
VII	Гадаад харилцааны сайд	2	2,600.0	2,600.0	1,528.0	58.77%	1,072.0
VIII	Сангийн сайд	11	297,625.7	175,100.0	28,867.3	16.49%	146,232.7
IX	Хууль зүй, дотоод хэргийн сайд	25	75,738.5	51,035.2	34,076.4	66.77%	16,958.8
X	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	42	57,897.0	25,456.9	1,678.5	6.59%	23,778.4
XI	Барилга, хот байгуулалтын сайд	241	488,539.5	250,987.5	68,093.0	27.13%	182,894.4
XII	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	614	1,838,973.2	662,421.5	129,565.8	19.56%	532,855.7
XIII	Зам, тээврийн хөгжлийн сайд	140	678,364.8	310,979.8	103,015.6	33.13%	207,964.3
XIV	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	3	5,930.0	4,202.9	-	0.00%	4,202.9
XV	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	37	28,963.0	15,192.9	1,589.3	10.46%	13,603.6
XVI	Эрчим хүчний сайд	34	202,710.8	72,623.5	8,219.7	11.32%	64,403.8
XVII	Эрүүл мэндийн сайд	131	293,212.4	133,756.2	29,324.5	21.92%	104,431.8
XVIII	Авлигатай тэмцэх газрын дарга	2	1,120.7	1,120.7	1,029.4	91.85%	91.3
XIX	Улсын ерөнхий прокурор	7	31,975.3	11,731.5	364.2	3.10%	11,367.3
XX	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	1	19,000.0	4,480.0	-	0.00%	4,480.0
XXI	Монгол Улсын Ерөнхий аудитор	2	1,000.0	1,000.0	415.4	41.54%	584.6
XXII	Үндэсний статистикийн хорооны дарга	1	650.7	650.7	331.6	50.97%	319.1
XXIII	Үндсэн Хуулийн цэцийн дарга	1	600.0	600.0	124.9	20.81%	475.2
УЛСЫН ТӨСВИЙН ДҮН		**1427**	**4,233,926.0**	**1,828,930.3**	**448,076.8**	**24.50%**	**1,380,853.4**
КОНЦЕССЫН ДҮН		**11**	**1,073,708.5**	**323,583.4**	**215,055.8**	**66.46%**	**108,527.6**
НИЙТ		**1438**	**5,307,634.5**	**2,152,513.6**	**663,132.6**	**30.81%**	**1,489,381.1**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх бүх төсөл, арга хэмжээнээс 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар гэрээ байгуулаагүй

262 төсөл, арга хэмжээнээс халуун усны барилга, хорооны цогцолбор, багийн иргэний танхим, соёлын төв, Засаг даргын Тамгын газрын барилга, сумын хүндэтгэлийн өргөө, цэнгэлдэх хүрээлэн, нийтийн эзэмшлийн байруудын дулаалга, засвар, тохижилт, гэрэлтүүлэг болон зарим салбаруудын их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг тэвчиж болох нийт 122 төсөл, арга хэмжээний **54.0** тэрбум төгрөгийг хасаж, мөн 380 шинэ болон шилжих төсөл, арга хэмжээний **456.4** тэрбум төгрөгийг бодит ажлын гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн бууруулж, 169 төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлтийн **3.2** тэрбум төгрөгийг хасаж нийт **513.6** тэрбум төгрөг болж байна.

Төсвийн тодотголоор шинээр нэмж хэрэгжүүлэх ХӨСҮТ-ийн лабораторийн барилгыг дуусгаж, тоног төхөөрөмжөөр хангах ажил болон ирэх жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв зэрэгт нийт **16.0** тэрбум төгрөгийг төсөвлөснөөр нийт санхүүжих дүнгийн цэвэр өөрчлөлт **497.6** тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллөөр 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтын зардалд **1,083.4** тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 2020 оны Төсвийн тодотголын саналын дагуу хасах 122 төсөл, арга хэмжээний 2021 он руу шилжих байсан **46.7** тэрбум төгрөг хасагдаж, санхүүжих дүнг бууруулах 380 төсөл, арга хэмжээний **417.0** тэрбум төгрөг 2021 он руу шилжин нэмэгдэж, 2021 он руу шилжих дүн **1,453.7** тэрбум төгрөг болохоор байна.

6. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэлийн үед төсвийн мөнгөн хөрөнгийн удирдлага, төлбөр гүйцэтгэх бэлэн байдлыг хангах зорилгоор төсвийн зарлагыг 2020 оны 2 дугаар сараас эхлэн эрүүл мэнд зэрэг онцгой салбаруудын бүх урсгал зардал түүнчлэн бүх шатны төсөвт байгууллагын цалин, тогтмол зардал, тэтгэвэр, тэтгэмжийг тэргүүн ээлжид санхүүжүүлэхээр, бусад зардлыг ач холбогдол, нэн шаардлагатай байдлыг нь харгалзан үзэж санхүүжүүлэхээр, харин гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зэрэг зардлын санхүүжилтийг түр хугацаагаар зогсоогоод байна.

Үүнтэй уялдуулан 2020 оны төсвийн тодотголд орон нутгийн суурь зарлагыг тооцохдоо мөн адил ач холбогдол, эрэмбэ дараалыг харгалзан үзэж зарим зардлыг бууруулж тооцсон. Нийт аймгуудын батлагдсан суурь зарлагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,399.3 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,640.5 сая төгрөгөөр, норматив зардлыг 171.6 сая төгрөгөөр, Эд хогшил, урсгал засварын зардлыг 4,002.5 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,908.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 5,952.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,200.8 сая төгрөгөөр бууруулах зохицуулалтыг хийсэн.

Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын дээрх өөрчлөлт нь аймгуудад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 2020 оны батлагдсан дүнгээс нийтдээ 8.2 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлж байна.

Төсвийн тухай хуулийн 56.2.2 дах заалтын дагуу үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг орон нутгийн төсөвт үлдээхээр заасан байдаг. 2020 оны батлагдсан төсөвт орон нутагт үлдэх хөрөнгийн хэмжээ 294.0 тэрбум байсан бол тодотголоор орсон өөрчлөлтөөр орон нутгийн хөрөнгө оруулалт 9.9 тэрбумаар буурч 284.1 тэрбум төгрөг байхаар 2020 оны тодотголын төсвийн төсөлд тусгалаа.

7. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн орлого төлөвлөснөөс дутуу төвлөрч, үүний улмаас Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-ийн эх үүсвэрүүд буурсан нь орон нутагт хийгдэх шилжүүлгүүд төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байхад нөлөөлж байна.

Үүнтэй холбоотойгоор аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын нийт шилжүүлэг батлагдсан хэмжээнээс 16.1 тэрбум төгрөгөөр буурч 172.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдлөө.

Хүснэгт № 19. Орон нутгийн хөгжлийн санд орсон өөрчлөлт,эх үүсвэрээр, сая төгрөг

№	Орлогын нэр төрөл	2020 БАТ	2020 ТОД	ЗӨРҮҮ
1	Дотоодын НӨАТ	41,000.0	33,837.5	-7,162.5
2	АМНАТ	64,680.0	60,607.6	-4,072.5
3	Урамшуулал	11,932.7	5,602.1	-6,330.6
4	Дэмжлэг	6,534.4	6,534.4	-
5	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	3,533.1	5,524.6	1,991.5
6	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	11,133.7	8,653.5	-2,480.3
7	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	13,732.5	10,673.3	-3,059.2
8	АМНАТ-Мега төсөл	35,858.1	40,873.8	5,015.7
	НИЙТ	**188,404.5**	**172,306.6**	**-16,097.9**

8. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Монгол Улсын 2020 оны төсөвт гадаад төслийн зээл, тусламжийн ашиглалт **1,346.6** тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2020 оны төсвийн тодотголд нийт **1,623.2** тэрбум төгрөгийн зээл, тусламжийг авч ашиглахаар төлөвлөгдлөө.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголын төсөлд дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- 2020 оны сүүлийн хагаст шинээр эхлэх болон зээлийн хэлэлцээрийн

шатанд байгаа төслүүдийн санхүүжилтийг 2021 онд шилжүүлэх;

✔ Зээл, тусламжийн шинэ эх үүсвэрийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн эдийн засгийг дэмжих, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн төслүүдэд чиглүүлэх;

✔ Үргэлжилж буй төслүүдийн хувьд сайн хэрэгжиж буй төслүүдийг түлхүү санхүүжүүлэх, 2020 онд дуусах төслүүдийн санхүүжилтийг олгох;

✔ Нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх.

Үүний үр дүнд 2020 оны төсвийн тодотголоор нийт гадаад төслийн зээлийн ашиглалт **276.6** тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцогдсоноос коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эдийн засгийг дэмжих, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хангамжийг сайжруулах бодлогын хүрээнд дараах хөрөнгө нэмж тусгагдлаа. Үүнд:

- Засгийн газрын 2 дахь багц арга хэмжээний хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох хөтөлбөрийн нэмэлт эх үүсвэрт **15.0** тэрбум төгрөг;
- Ажилчдад богино хугацааны тэтгэмж олгох буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил аж ахуй эрхлэгч, албан бус салбарын ажилчдад нийгмийн даатгалын тэтгэмж олгоход **42.4** тэрбум төгрөг;
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд **18.2** тэрбум төгрөг;
- Хүүхдийн мөнгө болон хүнсний талон хөтөлбөрүүдийн нэмэлт эх үүсвэрийг санхүүжүүлэхэд **74.8** тэрбум төгрөг;
- Нийслэлийн Хан-Уул дүүрэгт байрлах 300 ортой төрөх эмнэлэг, АШУҮИС-ийн дэргэдэх сургалтын эмнэлэг, Улсын Гуравдугаар Төв эмнэлэг, нийслэлийн 9 дүүргийн Нэгдсэн эмнэлэг, орон нутаг дахь нэгдсэн эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад **43.7** тэрбум төгрөг;
- ХӨСҮТ, УНТЭ, УГТЭ, ГССҮТ, 10 аймгийн Нэгдсэн эмнэлэг, 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, Дорнод аймгийн Халхгол, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Эрүүл мэндийн төвүүдэд нэн яаралтай тоног төхөөрөмж худалдан авахад **3.3** тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн салбарын нэн яаралтай тоног төхөөрөмжид **5.9** тэрбум төгрөг;
- Долоон аймгийн Нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийг шинэчлэх, КОВИД-19 болон амьсгалын замын хүнд, хурц хэлбэрийн халдвартай өвчтөнийг оношилж, эмчлэх лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүдийн эрчимт эмчилгээ болон түргэн тусламжийн үйлчилгээний чадавхыг сайжруулах чиглэлээр **51.0** тэрбум төгрөгийг тус тус зарцуулахаар тусгалаа.

9. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

9.1. Төсвийн тэнцэл

Шаардлагатай өөрчлөлтүүдийг Монгол Улсын 2020 оны төсвийн тодотголд тусгахад нэгдсэн төсвийн нийт орлого 2,170.7 тэрбум төгрөгөөр буурч 10,729.3 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт зарлага 704.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 14,577.5 тэрбум төгрөг болох ба төсвийн нийт тэнцэл -3,848.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -9.9 хувьтай тэнцэхээр байна.

Хүснэгт № 20. Нэгдсэн төсвийн үзүүлэлт , тэрбум төгрөг

	Бат-2020	Тод-2020	Зөрүү
НИЙТ ОРЛОГО	**12,900.0**	**10,729.3**	**-2,170.7**
Тогтворжуулалтын сан	125.2	55.2	-70.0
Ирээдүйн өв сан	977.0	943.2	-33.8
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	11,797.8	9,730.9	-2,066.9
НИЙТ ЗАРЛАГА	**13,872.6**	**14,577.5**	**704.9**
Урсгал зардал болон бусад	10,373.5	11,299.4	925.9
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	2,152.5	1,654.9	-497.6
Гадаад зээл, тусламж	1,346.6	1,623.2	276.6
НИЙТ ТЭНЦЭЛ	**-972.6**	**-3,848.2**	**-2,875.6**
ДНБ-д эзлэх хувь	-2.4%	-9.9%	-7.5%
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	**-2,074.7**	**-4,846.6**	**-2,771.8**
ДНБ-д эзлэх хувь	-5.1%	-12.5%	-7.4%

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 хэсэгт зүйлд заасан "*тухайн жилийн ДНБ өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад 0 эсхүл түүнээс бага бол*" мөн "*гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн ДНБ-ий 5 ба түүнээс дээш хувь бол*" гэсэн нөхцөлүүд зэрэг үүссэнээр нэгдсэн төсвийн 2020 оны тодотголд төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх хууль, эрх зүйн нөхцөл бүрдээд байна.

9.2. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын 2020 оны төсвийн алдагдал 4,847.9 тэрбум төгрөг болохоор байна. Үүнээс 3,311.3 тэрбум төгрөг нь эх үүсвэртэй бөгөөд Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдлээс 149.7 тэрбум төгрөгийг алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн. Түүнчлэн 1,195.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээгээр дотоодын зах зээл дээр Засгийн газрын үнэт цаас гаргана.

10. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 22.4 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний **58.9** хувьд хүрсэн бол 2019 оны жилийн эцэст 24.1 их наяд төрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний **55.6** хувьд хүрээд байна.

Засгийн газрын өр 2020 онд өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 62.2 хувьд хүрнэ.

Хүснэгт № 21. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2017	2018	2019
I. Засгийн газрын дотоод өр		3,461.9	1,564.7	1,399.6
1.1	Үнэт цаас	3,461.9	1,564.7	1,399.6
II. Засгийн газрын гадаад өр		16,857.8	18,865.6	20,728.1
2.1	Үнэт цаас	7,701.6	7,664.5	7,927.2
2.2	Зээл	9,156.2	11,201.1	12,800.8
III. Засгийн газрын бусад өр		2,431.9	1,936.7	2,072.1
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	1,663.7	1,130.7	1,076.3
3.2	“Барих-шилжүүлэх” төрлийн концесс	768.2	806.0	995.7
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)		**22,751.6**	**22,367.0**	**24,199.7**
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		**20,212.1**	**18,955.9**	**20,525.6**
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		**80.0%**	**75.0%**	**75.0%**
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		**72.5%**	**58.9%**	**55.6%**

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа шударга, өрсөлдөөнт зах зээлийн зарчимд нийцээгүй, банкны систем дэх мөнгөн хөрөнгийн байдал болон Монголбанкны шийдвэрийн нөлөөлөл өндөр байсан тул арилжааг зогсоож, 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авсан. Засгийн газрын үнэт цаасны арилжааг 2017 оны 10 дугаар сараас зогсоосон бөгөөд үнэт цаасны үлдэгдэл 4.6 их наяд төгрөгөөс 2019 оны жилийн эцэст 1.4 их наяд төгрөгт хүрч буурсан.

Засгийн газар шинээр өрийн баталгаа гаргахгүй байх, “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээг шинээр байгуулахгүй байх бодлогыг баримталснаар Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 3.5 их наяд төгрөгт хүрээд байсныг 2019 оны эхний хагас жилийн байдлаар 1.1 их наяд төгрөг болгон бууруулсан.

Түүнчлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх шаардлагатай эх үүсвэрийг урт хугацаатай, хөнгөлөлттэй гадаад зээлээр бүрдүүлж нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”, “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл”, “10 аймгийн төвд дулааны станц барих төсөл”, “Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”, "Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах төсөл”, “Эрчим хүчний II төсөл” зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсөвт тодотгол хийхтэй холбогдуулан эдийн засагт тулгамдаж буй нөхцөл байдлаас шалтгаалан макро үзүүлэлт буурч, шинээр хийх зээллэгийн хэмжээ нэмэгдэж

байгаагаас өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг тухайн жилийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан харьцаа 2020 онд 62.2 хувь, 2021 онд 58.4 хувь, 2022 онд 54.4 хувьд тус тус хүрэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангаж, цаашид буурах тооцоололтой байна.

График № 21. Засгийн газрын өрийн тусгай шаардлагын төсөөлөл, Засгийн газрын өр(ӨҮЦ)-ийн ДНБ-д эзлэх хувь



Эдийн засгийн макро үзүүлэлт болох ДНБ 2.0 их наяд төгрөгөөр буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханш 200.0 төгрөгөөр суларсан болон 521.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас арилжаалж, 1,054.6 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл нэмж авахаар төлөвлөснөөс Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-нд эзлэх хувь 2020 онд төлөвлөж байснаас 8 хувиар өндөр гарах тооцоололтой байна.

Төгрөгийн ханш суларсантай холбоотой хүү, шимтгэлийн зардал 2020 онд тооцоолж байснаас 12.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж **972.6** тэрбум төгрөгт хүрэх тооцоололтой байна.

График № 22. Хүүгийн зардлын 2020 оны задаргаа



Хүү, шимтгэлийн зардалд 2020 онд төлөхөөр тооцоолсон зардлын 61 хувийг гадаад үнэт цаасны хүү, 22 хувийг гадаад зээлийн хүү, үлдэх 17 хувийг дотоод үнэт цаасны хүүгийн зардал тус тус эзэлж байна.

Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 2021-2024 онд 2.9 тэрбум ам.доллар төлөгдөх хуваарьтай байгаа бөгөөд өрийн үйлчилгээний төлбөр 2020 онд төсвийн орлогын 19.0 хувь, 2021 онд 29.2 хувь, 2022 онд 38.4 хувьд хүрч, 2019 онтой харьцуулахад төсөвт үзүүлэх дарамт 2 дахин нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 22. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл, сая ам.доллар

№	Гадаад үнэт цаас	Дүн	Хүү	Төлөгдөх огноо
1	Мазаалай	500$	10.88%	2021.04.06
2	Чингис	1,000$	5.13%	2022.12.05
3	Гэрэгэ	800$	5.63%	2023.04.26
4	Хуралдай	600$	8.75%	2024.03.09

Нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь буурч, төсвийн сахилга бат сайжирч байгаа хэдий ч их хэмжээний гадаад өрийг дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал байна. Иймд эдгээр өр төлбөрийг эдийн засаг, төсөвт дарамт багатайгаар төлөх өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт тусгасан.

11.МАКРО ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

01 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн уналт удаан үргэлжлэх.

Одоогоор коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хэр удаан хугацаанд үргэлжлэх нь тодорхойгүй байна. ОУВС-гийн зүгээс энэ онд дэлхийн эдийн засаг 4.9 хувиар унана гэж таамаглаж байна. 2021 онд дэлхийн эдийн засаг богино хугацаанд эргэн сэргэх боломжтой гэж үзэж байгаа ч коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үргэлжлэх хугацаа, эдийн засагт үзүүлэх хор уршгийн хэмжээ тодорхойгүй, цаашид 2 дахь давлагаа дэгдэж, улс орнууд дахин хөл хорио чангатган, олон улсын худалдааны эргэлт саарах, хөрөнгө оруулалт буурах бодит эрсдэл байгааг судлаачид онцолж байна.

График № 23. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын 1 өдөрт шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо, 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар



Эх үүсвэр: Worldometers цахим хуудас

Үүнээс улбаалан дэлхийн эдийн засаг агшиж, манай улсын гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүний үнэ, эрэлт буурсан тохиолдолд төсвийн орлогын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

02 Цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарах.

Зарим аймгийн нутгаар хаваржилт хүнд байснаас 2020 оны эхний хагас жилд малын зүй бус хорогдол нэмэгдээд байна. Оны хоёрдугаар хагаст хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас өндөр байх, өвөлжилт хүндрэх тохиолдолд цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын өсөлт, бүтээмж төсөөлсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж, хүнсний бүлгийн үнийг хөөрөгдөх талтай.

12. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын хэмжээг 1,411.7 тэрбум төгрөг, улсын төсвийн татаасны хэмжээг 399.4 тэрбум төгрөг, нийт тэтгэвэр, тэтгэмж, үйл ажиллагааны зардлын хэмжээг 2,494.0 тэрбум төгрөгөөр тус тус тооцов. Энэ нь Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсан нийт орлогын хэмжээнээс 880.0 тэрбум төгрөгөөр, зарлагын хэмжээнээс 16.6 тэрбум төгрөгөөр тус тус буурч байна.

Хүснэгт № 23. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлт		2020 Бат	2020 Тод	Зөрүү
ОРЛОГО		**2,291.9**	**1,411.7**	**-880.2**
ЗАРЛАГА		**2,510.7**	**2,494.0**	**-16.6**
1	Тэтгэврийн даатгалын сан	2,253.0	2,173.0	-80.0
2	Тэтгэмжийн даатгалын сан	143.8	143.8	-
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	35.0	35.0	-
4	Ажилгүйдлийн даатгалын сан	51.1	115.1	64.0
5	Үйл ажиллагааны зардал	27.8	27.2	-0.6
Улсын төсвөөс олгох татаас		**399.4**	**399.4**	**-**

Олон улсад тархаад байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас үүсээд буй нөхцөл байдлыг даван туулах, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг Улсын Их Хурлаар 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр батлан хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн орлого, зарлагын хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого

1. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасны дагуу коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч, түүнчлэн сайн дураар даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлсөн. Уг арга

хэмжээнд нийт 38.4 мянган аж ахуйн нэгжийн 401.8 мянган даатгуулагч, 144.3 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж 4, 5, 6 дугаар саруудад нийт 271.0 тэрбум төгрөгийн чөлөөлөлт хийгээд байна.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хүндрэлтэй цаг үед иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл чөлөөлөлтийн бодлогын арга хэмжээг он дуустал хэсэгчлэн үргэлжлүүлнэ.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж байгаа ажил олгогч болон даатгуулагчийн төлөх Нийгмийн даатгалын шимтгэлийг "тэглэсэн" арга хэмжээ 2020 оны 10 дугаар сарын 1-ээр дуусгавар болно. Уг арга хэмжээг 2020 оны 10-12 дугаар саруудад шимтгэлийн "хөнгөлөлт" байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр тооцов. Ингэхдээ шимтгэл "тэглэх" арга хэмжээнд хамрагдсан ААН, даатгуулагчийн төлөх шимтгэлийг ажил олгогч 5%, даатгуулагч 5%, сайн дураар даатгуулагчдыг мөн 5% байхаар тооцлоо.

Дээрх арга хэмжээнүүдийг он дуустал хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын сангийн орлого анх батлагдсан дүнгээс нийт 880.0 орчим тэрбум төгрөгөөр буурах тооцоотой байна. Үүнийг дараах эх үүсвэрээс шийдвэрлэхээр тооцлоо. Үүнд:

1. Капитал банк татан буугдахад тус банканд байршиж байсан Нийгмийн даатгалын сангийн 104.2 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах.

2. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу компанийн гаргасан үнэт цаасыг Монголбанк эзэмших хүртэл хугацаа буюу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл арилжааны банканд байршуулсан Нийгмийн даатгалын сангийн 452.5 тэрбум төгрөгийг чөлөөлөх.

Нийгмийн даатгалын сангийн зарлага

1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хүрээнд 2020 онд 88.0 орчим мянган иргэн хамрагдан тэтгэврийн даатгалын санд 133.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 34.8 мянган малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэвэрт 117.3 тэрбум төгрөг зарцуулахаар нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсөвт тусгагдсан боловч олон улсад тархаад байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас 2020 оны эхний 5 сарын байдлаар 2911 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдан тэтгэврийн даатгалын шимтгэлд 4.6 тэрбум төгрөг төлсөн нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр жилийн эцэст 42.2 тэрбум төгрөг санд орж, 37.3 тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулахаар байна. Иймд хуулийг хэрэгжүүлэхэд хэмнэгдэж буй тэтгэврийн даатгалын сангийн зарлагын төсвийг 80.0 тэрбум төгрөгөөр бууруулж үүнээс ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх дэмжлэгт шаардагдах 64.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шилжүүлэн шийдвэрлэх;

2. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан 6.9 мянган аж ахуйн нэгжийн 73.0 мянга орчим ажилчдад сард 200.000 төгрөг буюу нийт 25.2 тэрбум төгрөгийг олгосон ба хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 64.0 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоотой байгаа тул холбогдох зардлыг хэмнэлттэй байгаа сангаас шилжүүлэн шийдвэрлэхээр тооцов.

3. Төсвийн боломжтой уялдуулан зарим тэвчиж болох үйл ажиллагааны зардлыг бууруулах.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эдийн засгийг сэргээж аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих, иргэдийн орлого, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр УИХ, Засгийн газраас хэрэгжүүлсэн багц арга хэмжээний зарим хэсгийг 2020 он дуустал үргэлжлүүлэх, үүнтэй холбогдуулан тэвчиж болох урсгал зардлыг боломжит хэмжээнд нь хүртэл бууруулах шаардлага үүсэж байгаатай холбоотойгоор сангийн үйл ажиллагааны зардлыг 0.6 тэрбум төгрөгөөр бууруулсан.

13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай хуульд орлогыг нийт 506.5 тэрбум төгрөгөөр буюу сангийн орлогыг батлагдсан төсвөөс өөрчлөлтгүй байхаар тооцсон.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалж эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн тоо багассан, сангаас хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тохиолдлын тоогоор олгодог санхүүжилт буурч байгаа зэрэг шалтгаанаар сангийн зарлагыг 2020 оны батлагдсан төсвөөс 12.0 тэрбум төгрөгөөр буурахаар тооцож 494.5 тэрбум төгрөгөөр төсөвлөлөө. Үүнээс: 63 хувь буюу 320.0 тэрбум төгрөгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад, 26 хувь буюу 130.5 тэрбум төгрөгийг төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллагад, 8 хувь буюу 37.2 тэрбум төгрөгийг эмийн үнийн хөнгөлөлт олгоход зориулж эмийн сангуудад байхаар тооцсон ба эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийг 5.4 тэрбум төгрөг буюу 2020 оны батлагдсан дүнг нэмэгдүүлэхгүй байхаар тооцсон.

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцинд эрсдэл хамгийн өндөр эмнэлгийн ажилчид, ОБЕГ, ЦЕГ, ХХЕГ, ЗХЖШ, МХЕГазрын албан хаагчид, 65-аас дээш насны хүн ам, 2-5 хүртэлх насны хүүхэд жирэмсэн эмэгтэйчүүдийг хамруулахад 12.5 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон.

Жил бүр улирлын чанартай дэгдэлт ихэсдэг улирлын томуугийн вакциныг 6-18 насны хүүхдүүдийг хамруулахаар тооцож 9.8 тэрбум төгрөг төсөвлөлөө.

Хүснэгт № 24. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого зарлага, тэрбум төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2020 БАТ	2020 ТОД	Зөрүү
ОРЛОГО	**506.5**	**506.5**	**-**
ЗАРЛАГА	**506.5**	**494.5**	-12.0
Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад	297.7	320.0	22.3
Үүнээс: Улсын төсөвт	246.3	246.3	-
Аж ахуйн тооцоот	42.6	42.6	-
Сум тосгоны эрүүл мэндийн төв	8.7	8.7	-
КОВИД-19, улирлын томуугийн вакцин		22.3	22.3
Төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад	168.8	130.5	-38.3
Эмийн санд олгох	33.3	37.2	4.0
Үйл ажиллагааны урсгал зардал	5.4	5.4	-
Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1.1	1.1	-
Бусад	0.2	0.2	-
ТЭНЦЭЛ	**0**	**12.0**	**12.0**

o O o

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 08 дугаар
сарын ..-ны өдөр Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх” гэснийг “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх” гэж, 2 дугаар зүйлийн “2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх” гэснийг “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх” гэж, 6 дугаар зүйлийн “2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх” гэснийг “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх,
чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас үүдэн дэлхийн улс орнуудын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд эрсдэл тулгараад байгаа билээ.

Монгол Улсын Засгийн газар коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас сэргийлэх үүднээс ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортыг түр хугацаагаар зогсоох, бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах дээрх арга хэмжээ нь татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгж, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн хүндрэл бий болгосон.

Үүсээд буй нөхцөл байдлыг харгалзан үзэж Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолыг баталсан.

Энэ тогтоолын хүрээнд Улсын Их Хурал Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуулийг баталж, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 2020 оны 10 дугаар сарын 1-нийг хүртэл, түрээсийн төлбөр бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод ногдох албан татварыг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд чөлөөлөх арга хэмжээг авсан.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын иргэдийн эрүүл мэндэд учруулж болох эрсдэл, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө ирэх саруудад үргэлжлэх төлөвтэй байна.

Иймээс жижиг, дунд бизнес эрхлэгчид, түрээслэгчдийг үргэлжлүүлэн дэмжих зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг боловсруулаа.

Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татвар болон түрээсийн төлбөр бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод ногдох албан татварыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөхөөр хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд, түрээслэгчид орлогын албан татварын дэмжлэгийг үргэлжлүүлэн эдлэх нөхцөл бүрдэх юм.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 08 дугаар
сарын ..-ны өдөр Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 3 дугаар зүйлийн “2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх” гэснийг “2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас үүдэн дэлхийн улс орнуудын санхүү, эдийн засаг болон хүн амын эрүүл мэндэд эрсдэл тулгараад байгаа билээ.

Улс орнууд энэхүү халдварт өвчний улмаас үүссэн эрсдэлийг бууруулах чиглэлээр өөрсдийн нөөц бололцоог дайчилж иргэд болон татвар төлөгч бизнесийн байгууллагад төрөл бүрийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлж байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтаас үүдэлтэй эдийн засгийн сорилтыг даван туулахад иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх практик шаардлага бий болсон тул тархалтаас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор халдварын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн албан татвараас чөлөөлөх зорилгоор Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Импортоор оруулж ирж байгаа Коронавируст халдвар (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлөхөөр хуульд заасан.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын иргэдийн эрүүл мэндэд учруулж болох эрсдэл буурахгүй, цаашид үргэлжлэхээр байгаа тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн үйлчлэх хугацааг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл сунгахаар төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл импортоор оруулж ирж байгаа Коронавируст халдвар (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвараас чөлөөлөх боломж бүрдэнэ.

---o0o---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 08 дугаар
сарын ..-ны өдөр Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 3 дугаар зүйлийн “2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх” гэснийг “2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас үүдэн дэлхийн улс орнуудын санхүү, эдийн засаг болон хүн амын эрүүл мэндэд эрсдэл тулгараад байгаа билээ.

Улс орнууд энэхүү халдварт өвчний улмаас үүссэн эрсдэлийг бууруулах чиглэлээр өөрсдийн нөөц бололцоог дайчилж иргэд болон татвар төлөгч бизнесийн байгууллагад төрөл бүрийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлж байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтаас үүдэлтэй эдийн засгийн сорилтыг даван туулахад иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх практик шаардлага бий болсон тул тархалтаас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор халдварын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн албан татвараас чөлөөлөх зорилгоор Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Импортоор оруулж ирж байгаа Коронавируст халдвар (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр хуульд заасан.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын иргэдийн эрүүл мэндэд учруулж болох эрсдэл буурахгүй, цаашид үргэлжлэхээр байгаа тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн үйлчлэх хугацааг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл сунгахаар төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл импортоор оруулж ирж байгаа Коронавируст халдвар (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх боломж бүрдэнэ.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... сарын ... өдөр Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх тоног төхөөрөмжид тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг дараагийн төсвийн жилийн эхний улиралд татвар төлөгчид буцаан олгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны ... дүгээр сарын ...-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас хөнгөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... сарын ... өдөр Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх тоног төхөөрөмжийг 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

“Гаалийн албан татвараас хөнгөлөх тухай, Гаалийн албан татвараас хөнгөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн төслүүдийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.22-т “Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ”, 4.2.23-т “Мал, амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан болно.

Дээрх заасны хүрээнд түүхий эдийн бэлтгэлийн системийг боловсронгуй болгож, түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэл нэмүү өртөг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх тоног төхөөрөмжийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөх бөгөөд хөнгөлөлтийн хэлбэр нь тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг дараагийн төсвийн жилийн эхний улиралд татвар төлөгчид буцаан олгохоор хуулийн төслийг боловсруулаа.

------o0o------

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... сарын ... өдөр Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх тоног төхөөрөмжийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

“Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.22-т “Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ”, 4.2.23-т “Мал, амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан болно.

Дээрх заасны хүрээнд түүхий эдийн бэлтгэлийн системийг боловсронгуй болгож, түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэл нэмүү өртөг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх тоног төхөөрөмжийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулаа.

------o0o------

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 14.2 дахь хэсэг нэмсүгэй.

“14.2.Энэ хуулийн 10.4.2, 11.1.1 дэх заалтыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр батлагдсан боловч хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан дараах хүндрэл үүсээд байна. Үүнд:

1.Хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг батлахаар заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн А/396 дугаар тушаалаар уг жагсаалтыг баталсан.

Тушаалд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасны дагуу сургуулийн орчныг сургуульд эзэмшүүлсэн газар түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газрыг хамааруулж, ундааны зүйлс, амттан зууш, боловсруулсан, хагас боловсруулсан хүнс, түргэн хоол гэсэн 3 бүлэгтэй, нийт 20 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглохоор тусгасан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас /хуучнаар/ 2019 оны 04 дүгээр сард хийсэн судалгаагаар ерөнхий боловсролын 781 сургуулийн орчинд 3043 хүнсний худалдаа, үйлчилгээний газар үйл ажиллагаа явуулж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасныг үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг дагаж мөрдөх хугацааг түр хугацаагаар хойшлуулах шаардлага үүсээд байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 662 сургуулиас орон нутагт байрлах 485 сургуулийн 37 буюу 7.6 хувь, нийслэлийн 140 сургуулийн 122 буюу 87 хувь нь аж ахуй нэгжтэй түрээсийн гэрээ байгуулан үдийн цайны үйлчилгээг үзүүлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын байр, талбай, тоног төхөөрөмжийг түрээслүүлэх, сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнээс бусад зориулалтаар ашиглахыг хориглохоор хуульчилсан.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийг танхимын хэлбэрээр хичээллүүлэхээр болсонтой холбогдуулан суралцагчдад үдийн цайг үргэлжлүүлэн өгнө.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн байрыг стандартын шаардлага хангуулах, зориулалтын тоног төхөөрөмжөөр бүрэн хангахад 37.3 тэрбум төгрөг шаардлагатай байгаа бөгөөд мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, хүнсний хангамжийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх зэрэг асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж ажиллана.

Дээрх асуудлыг шийдвэрлэх төсөв 2020 оны улсын төсөвт тусгагдаагүй тул 662 ерөнхий сургуулийн сургуулийн 342.6 мянган суралцагчдад үдийн цайны үйлчилгээг үзүүлэх боломжгүй нөхцөл үүсээд байгаатай холбогдуулан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг дагаж мөрдөх хугацааг хойшлуулах шаардлагатай байна.

Иймд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.4.2, 11.1.1 дэх заалтыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуулийн төслийг боловсруулаа.

---o0o---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмсүгэй:

“12.6.Энэ хуулийн 11.1-д заасан баримт бичгийг бүрдүүлэх, хүлээн авах, мэдээллийн сан үүсгэх, түүнийг солилцох үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.”

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хуулийн дагуу төрийн байгууллагуудаас 118 тусгай зөвшөөрөл олгохоор тусгагдсан. Уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно гэж доод хугацааг заасан байдаг боловч ихэнхдээ 3 жилээр олгож 3 жил тутам дахин баримт бичиг бүрдүүлж хугацааг нь сунгуулдаг.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийг тодорхойлсон бөгөөд тухайн үйл ажиллагааны төрлөөс хамаарч нарийвчилсан хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглосон. Эрх бүхий этгээдээс тусгай зөвшөөрөл олгохдоо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хуульд заасан шаардлагыг үндэслэн баримт бичиг хүлээж авч байгаа боловч энэхүү баримт бичгийг хүлээж авах, буцаах үйл ажиллагааг зохицуулсан журам байдаггүй, журам батлах эрхийг хуулиар олгоогүй учраас хуулийг хэрэгжүүлэхэд зарим хүндрэл учруулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-т төрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүнд инновацийг нэвтрүүлэх арга замын нэг нь цахим засаглалыг хөгжүүлэх үндсэн зорилгыг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ зорилгын хүрээнд хуульд заасан тусгай зөвшөөрлийг хялбаршуулах, түргэн шуурхай болгох үүднээс тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, олгох ажлыг хэрэгжүүлэхэд тухайн баримт бичигт тавигдах техникийн шаардлага, баримт бичгийг хүлээн авах, түүнийг бүртгэх зэрэг харилцааг тусгайлан зохицуулах шаардлага бий болж байна. Иймд энэхүү харилцааг Засгийн газраас батлах журмаар зохицуулахаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулла.

---o0o---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5^1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5^1. Ирээдүйн өв сангийн хөрөнгийг 2025 он хүртэл Засгийн газрын гадаад өрийн дарамтыг харгалзан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хуримтлуулна."

2 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5^2 дугаар зүйлийн "энэ хуулийн 5^1 дүгээр зүйлд заасны дагуу Корпораци бие даан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болсноор" гэснийг "2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаар үндэсний баялгийг өнөө ба хойч үеийнхэнд шударга, тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн орлогоос хуримтлал үүсгэх үүрэгтэй Ирээдүйн өв санд 2019 оны 7 дугаар сараас хуримтлал үүсэж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу тус сан нь орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн бөгөөд сангийн хөрөнгө төрийн сангийн дансанд байршиж байна.

Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг мэргэжлийн, бие даасан, 100 хувь төрийн өмчит хуулийн этгээд буюу “Ирээдүй өв сан корпораци” хэрэгжүүлэхээр хуульчилсан бөгөөд хуримтлал дөнгөж эхэлж байгаа үед олох хөрөнгө оруулалтын орлого нь шинээр байгуулагдах бүтцийн зардлыг даахгүй байх, түүнчлэн хөрөнгийн удирдлагын чадавх бүрдээгүй нөхцөлд сангийн хөрөнгийг эрсдэлд оруулахаар байна.

Сангийн яамнаас Ирээдүйн өв сангийн хөрөнгийг хамтран удирдахын зэрэгцээ дотоодын хүний нөөцийн болон институцийн чадавхыг бүрдүүлэх техникийн туслалцааг авахаар Дэлхийн банкны нөөцийн удирдлагын хөтөлбөр (RAMP)-т хамрагдах албан хүсэлтээ 2019 оны 12 дугаар сард хүргүүлж, олон улсад нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банкнууд болон мэргэшсэн хөрөнгө оруулалтын компаниудтай холбоо тогтоон, хамтран ажиллах саналыг тавьсан. Улмаар, Дэлхийн банкны зүгээс өөрсдийн багийг 5 дугаар сард Монгол Улсад ажиллуулахаар шийдвэрлээд байсан бол хөрөнгө оруулалтын банк, мэргэшсэн компаниудын хувьд Монгол Улсад ажиллан “know your client” буюу харилцагчийн үнэлгээг хийж, харилцагчаа танин мэдэх ажиллагаа хийгдсэний дараа хамтран ажиллах боломжтойгоо мэдэгдээд байна. Гэвч, коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын дэгдэлт, хорионы улмаас холбогдох экспертүүд Монгол Улсад ирж ажиллах боломжгүй болж, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах асуудал тодорхойгүй хугацаагаар хойшлогдож байна.

Түүнчлэн, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.7-д дахь заалтад “Сангийн хөрөнгийг зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулах”-аар заасан бөгөөд коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас гадаад улс орнуудын үнэт цаасны өгөөж болон хувьцааны индексүүд өндөр уналттай байгаагаас сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн зах зээлд санхүүгийн хэрэгсэлд байршуулахад үнэ цэнийн алдагдалд орох эрсдэлтэй байгаа төдийгүй 2021-2024 онуудад Засгийн газрын гадаад бондын төлбөрт 2.9 тэрбум ам.доллар төлөгдөхөөр байгаатай зэрэгцэн Ирээдүйн өв сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн зах зээлд гарган удирдах нь төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд үзүүлж байгаа дарамтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Засгийн газрын өр, санхүүгийн хөрөнгийн удирдлагын орлого, зардлыг харьцуулж үзвэл ашигтай бус байна.

Дэлхий даяар тархсан Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас олон улсын санхүүгийн зах зээлд үүсээд байгаа тодорхойгүй байдал, Монгол Улсын төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд ирж байгаа дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор Ирээдүйн өв сангийн хөрөнгийг 2025 он хүртэл Засгийн газрын гадаад өрийн дарамтыг харгалзан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн сангийн нэгдсэн дансыг

удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн санд хуримтлуулахаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Ирээдүйн өв сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төрийн санд хуримтлуулж, санхүүгийн зах зээлд үүсэж байгаа эрсдэлээс хамгаалж, 2025 он хүртэл төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд нэмэлт дарамт үзүүлэхээс сэргийлэх боломж бүрдэнэ.

---o0o---

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 41.1.16 дахь заалт нэмсүгэй:

“41.1.16.Монгол Улсын Хөгжлийн банкнаас гаргасан нэхэмжлэл”

2 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль 2011 онд анх батлагдаж, 2017 онд шинэчилсэн найруулга нь батлагдан, банкны эрх зүйн орчинд шинэчлэл хийгдсэн. Гэсэн хэдий ч тус банкны үйл ажиллагааг улам сайжруулах, үр ашигтай ажиллах боломжийг нэмэгдүүлэх, чанаргүй зээлийг төлүүлэхийн тулд Хөгжлийн банкнаас шүүхэд нэхэмжлэл гаргахтай холбогдуулан төлж байгаа улсын тэмдэгтийн хураамжийг чөлөөлөх шаардлага бий болж байна.

Монгол Улсын Хөгжлийн банк нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн **дагуу** шүүхэд нэхэмжлэл гаргахад тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч тэмдэгтийн хураамж төлдөг. Энэхүү хураамж нь банкнаас олгож байгаа зээлийн онцлогоос хамаарч өндөр үнийн дүнтэй байдаг.

Хөгжлийн банкнаас 2018 оны 1 дүгээр сараас эхлэн чанаргүй зээлийг эргэн төлүүлэх ажиллагаа хийж эхэлсэн бөгөөд 2018, 2019 онуудад батлагдсан банкны жилийн төсөвт тусгагдсан улсын тэмдэгтийн хураамжийн зардал нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу шүүхэд гаргаж байгаа нэхэмжлэлийн дүнгээс тооцон төлөхөд хүрэлцдэггүй.

Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөхийн тулд холбогдох хуулийн дагуу төрийн төлөөллийг хэрэгжүүлж шүүхэд нэхэмжлэл гаргуулах тухай хүсэлтийг хувьцаа эзэмшигч болох Засгийн газраас Улсын Ерөнхий прокурорын газарт хүргүүлж, улмаар хамтран ажиллаж байгаа боловч Улсын Ерөнхий прокурорын газрын Мөрдөн шалгах хэлтсийн Төрийг шүүхэд төлөөлөх албаны прокурорын тоо (энэ чиглэлээр 2 прокурор ажилладаг), ажлын ачааллын улмаас шүүхэд хандаж нэхэмжлэл гаргах үйл явц удаашралтай, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд Монгол Улсын Хөгжлийн банкийг гуравдагч этгээдээр татаж оролцуулах зайлшгүй шаардлагатай болдог зэрэг нөхцөл байдал нь чанаргүй зээлийн төлбөрийг бууруулах ажилд ахиц гарахгүй байх нэгэн шалтгаан болж байна.

Улсын Ерөнхий прокурорын газраар дамжуулан их хэмжээний дүнтэй чанаргүй 6 зээлийн төлбөрийг шүүхэд нэхэмжилж, улсын тэмдэгтийн хураамжид 3,569,192,617 төгрөг төлөхөөс чөлөөлөгдсөн боловч энэ үйл ажиллагаа нь процесс ихтэй, удаашралтай байдаг.

Монгол Улсын Хөгжлийн банк 2018 оны 1 дүгээр сараас хойш чанаргүй 18 зээлийн төлбөрийг гурван шатны шүүхээр шийдвэрлүүлэхэд улсын тэмдэгтийн хураамжид 1,694,195,612 төгрөгийг төлсөн байна. Одоогоор хуримтлагдсан байгаа чанаргүй зээлийг шүүхийн журмаар эргэн төлүүлэхэд улсын тэмдэгтийн хураамжид 3 тэрбум орчим төгрөг төлөхөөр байна.

Иймд хуульд нэмэлт оруулснаар шүүхэд нэхэмжлэл гаргах ажил нэг шат ахиж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах боломж бүрдэнэ.

---o0o---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 9.5.4 дэх заалт нэмсүгэй:

"9.5.4.Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно."

2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2, 9.10.3 дахь заалтын "үйл ажиллагааны хөтөлбөр" гэснийг "үйл ажиллагааны хөтөлбөрийн" гэж, 9.3.4 дэх заалтын "чиглэл" гэснийг "чиглэлийн" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтын "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө," гэснийг, 9.3.2, 9.3.4 дэх заалтын "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний", 9.10.1 дэх заалтын "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг" гэснийг, 9.10.3 дахь заалтын "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний" гэснийг, 9.11.1 дэх заалтын "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.10 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.2.6, 9.4.3, 9.5.3 дахь заалт, 18 дугаар зүйлийг бүхэлд нь тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдаж 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгагдсан.

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал хамаарахаар тусгагдсан. Энэхүү өөрчлөлттэй холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хуулийн зарим нэр томьёо хоёр өөр байдлаар тусгагдаж, чиг үүргийн давхардал үүссэн нь хууль хоорондын уялдааг хангах зайлшгүй шаардлагыг бий болж байна. Иймд эдгээр зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулав.

---o0o---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн дараах зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсэг:

“8.11.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална:

8.11.1.төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;

8.11.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг хүлээн авч нэгтгэн, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт хүргүүлэх;

8.11.3.Засгийн газар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хянан хэлэлцэж, жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8.11.4.Улсын Их Хурал Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 6 дугаар сарын 1-ний дотор хэлэлцэн батлах.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.55 дахь заалт:

“4.1.55.“улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“61.2.Энэ хуулийн 61.1.1-61.1.3, 61.1.5-61.1.7-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс, 61.1.4-т заасан чиг үүргийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусгай зориулалтын шилжүүлгээр тус тус санхүүжүүлнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс 2 дугаар зүйлийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдаж 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгагдсан. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал хамаарахаар тусгагдсан. Энэхүү өөрчлөлттэй холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хуулиудын зарим нэр томьёо хоёр өөр байдлаар тусгагдаж, чиг үүргийн давхардал үүссэн нь хууль хоорондын уялдааг хангах зайлшгүй шаардлагыг бий болж байна.

Иймд дээр дурдсан зөрчилтэй байдлыг арилгах зорилгоор Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, батлуулах цагалбар” гэсэн хэсэг, 4 дүгээр зүйлд нэр нэр томьёог тайлбарласан заалтыг тус тус шинээр нэмэхээр хуулийн төсөл боловсруулав.

2. Эрүүл мэндийн салбарын одоогийн санхүүжилтийн тогтолцооны үр дагавар нь улсын эмнэлгүүдийн ачаалал, хүлээгдэл, иргэний бухимдлыг бий болгож, хувийн эмнэлгээс үйлчилгээ авсан орлого багатай иргэд санхүүгийн эрсдэлд орж байна. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо үр ашиггүй байгаа нь эмчилгээний чанар, хүртээмж хангалтгүй болоход нөлөөлж улмаар иргэдийн хоёрдогч болон лавлагаа шатлалын эмнэлэг рүү хандах урсгал нь эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд Эрүүл мэндийн даатгалын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулж эрүүл мэндийн байгууллагад олгох санхүүжилтийг нэг худалдан авагчийн зарчмаар буюу улсын төсвийн санхүүжилтийн эрүүл мэндийн даатгалаар дамжуулан үр дүнтэй хуваарилах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт оруулах хуулийн төслүүд боловсруулсан болно. Эдгээр хуулийн төслүүдийн нэг нь Төсвийн тухай хуульд оруулах өөрчлөлт бөгөөд анхан шатлалын тусламж үйлчилгээнд олгох төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгасан болно.

---o0o---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “-жендерийн хөгжлийн асуудал;” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэснийг “үндсэн чиглэл” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”, 3 дахь хэсгийн “Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө,” 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8-ын “-жендерийн хөгжлийн асуудал;” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдаж 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгагдсан.

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал хамаарахаар тусгагдсан. Энэхүү өөрчлөлттэй холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хуулиудын зарим нэр томьёо хоёр өөр байдлаар тусгагдаж, чиг үүргийн давхардал үүссэн нь хууль хоорондын уялдааг хангах зайлшгүй шаардлагыг бий болж байна.

2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2-д “Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудал хамаарна”, “Монгол Улсын Ерөнхий сайд Жендерийн үндэсний хороог тэргүүлж, түүний үйл ажиллагааг удирдлагаар хангана.” гэж заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дах хэсгийн 8-д Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд “жендерийн хөгжлийн асуудал” гэж заасантай зөрчилдөж байна. Мөн “Монгол Улс ахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолын 4.1-д Жендерийн үндэсний хорооны ажлын албыг бие даасан бүтэцтэйгээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий сайдад чиглэл өгсөн. Иймд эдгээр зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулав.

---o0o---

3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ
САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтад "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх", 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтад "урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах" гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

1.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасны дагуу Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч, түүнчлэн сайн дурын даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлсөн. Уг арга хэмжээнд нийт 38.4 мянган аж ахуйн нэгжийн 401.8 мянган даатгуулагч, 149.2 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж 2020 оны 4, 5, 6 дугаар саруудад нийт 271 тэрбум төгрөгийн чөлөөлөлт хийгээд байна. Хуулийг 2020 оны 10 дугаар сар хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлж, цаашид он дуустал хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлэхээр тооцоход нийгмийн даатгалын сангийн орлого их хэмжээгээр буурахаар байна.

2.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн үйлчлэлд 2020 онд 88.0 орчим мянган иргэн хамрагдан

тэтгэврийн даатгалын санд 133.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 34.8 мянган малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэвэрт 117.3 тэрбум төгрөг зарцуулахаар нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсөвт тусгагдсан боловч олон улсад тархаад байгаа Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас 2020 оны эхний 5 сарын байдлаар 2911 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдан тэтгэврийн даатгалын шимтгэлд 4.6 тэрбум төгрөг төлсөн нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр жилийн эцэст 42.2 тэрбум төгрөг санд орж, 37.3 тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулахаар байна. Үүнтэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын сангийн зарлагын төсвийг 80.0 тэрбум төгрөгөөр бууруулах, ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх дэмжлэгт шаардагдах 64.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шилжүүлэн шийдвэрлэх шаардлагатай байна.

3.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед эдийн засгийг сэргээж аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих, иргэдийн орлого, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр Улсын Их Хурал Засгийн газраас хэрэгжүүлсэн багц арга хэмжээний зарим хэсгийг 2020 он дуустал үргэлжлүүлэх, үүнтэй холбогдуулан тэвчиж болох урсгал зардлыг боломжит хэмжээнд нь хүртэл бууруулах шаардлага үүсэж байгаатай холбоотойгоор сангийн үйл ажиллагааны зардлыг 0.6 тэрбум төгрөгөөр бууруулах шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан орлогын хэмжээ болон 4 дүгээр зүйлд заасан зарлагын хэмжээг тус тус өөрчлөхөөр тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу 2020 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй хамт Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

--- oOo ---

<u>ТӨСӨЛ</u>

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...ны өдөр Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд**	**1,811,158.7**
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	467,463.3
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	517,638.4
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	246,658.3
	1.4 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	18,923.1
	1.5 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	122.5
	1.6 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	105,522.4
	1.7 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,059.5
	1.8 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,038.5
	1.9 Бусад орлого	50,315.1
	1.10 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	399,417.6
2	**Эрүүл мэндийн сайд**	**1,100.0**
	2.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	1,100.0
	Нийт орлого	**1,812,258.7**

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд**	**2,494,043.3**
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	2,172,968.7
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	143,758.6
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	35,042.1
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	115,064.9
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	27,209.0
	Нийт зарлага	**2,494,043.3**

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

НДС-ийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын хэмжээг 1,411.7 тэрбум төгрөг, улсын төсвийн татаасны хэмжээг 399.4 тэрбум төгрөг, нийт тэтгэвэр, тэтгэмж, үйл ажиллагааны зардлын хэмжээг 2,494.0 тэрбум төгрөгөөр тус тус тооцов. Энэ нь Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар баталсан нийт орлогын хэмжээнээс 880 тэрбум төгрөгөөр, зарлагын хэмжээнээс 16.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлт болж байна.

Хүснэгт № 1. НДС орлого, зарлага /тэрбум төгрөг/

	Үзүүлэлт	2020 төсөв	2020 Тод	Зөрүү
ОРЛОГО		**2,291.9**	**1,411.7**	**-880.2**
ЗАРЛАГА, үүнээс:		**2,510.7**	**2,494.0**	**-16.6**
1	Тэтгэврийн даатгалын сан	2,253.0	2,173.0	-80
2	Тэтгэмжийн даатгалын сан	143.8	143.8	0
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	35	35	0
4	Ажилгүйдлийн даатгалын сан	51.1	115.1	64
5	Ажиллагааны зардал	27.8	27.2	-0.6
Улсын төсвөөс олгох татаас		**399.4**	**399.4**	**-**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг Улсын Их Хурлаар 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр батлан хэрэгжүүлж байна. Хууль хэрэгжүүлэхтэй холбоотой нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн орлого, зарлагын хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна.

<u>Нийгмийн даатгалын сангийн орлого</u>

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасны дагуу коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч, түүнчлэн сайн дураар даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлсөн. Уг арга

хэмжээнд нийт 38.4 мянган аж ахуйн нэгжийн 401.8 мянган даатгуулагч, 144.3 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж 4,5,6 дугаар саруудад нийт 271 тэрбум төгрөгийн чөлөөлөлт хийгээд байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж байгаа ажил олгогч болон даатгуулагчийн төлөх Нийгмийн даатгалын шимтгэлийг "тэглэсэн" арга хэмжээ 2020 оны 10 дугаар сарын 1-ээр дуусгавар болно. Төсвийн тодотголд уг арга хэмжээг 2020 оны 10-12 дугаар саруудад шимтгэлийн "хөнгөлөлт" байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд шимтгэл "тэглэх" арга хэмжээнд хамрагдсан ААН, даатгуулагчийн төлөх шимтгэлийг ажил олгогч 5%, даатгуулагч 5%, сайн дураар даатгуулагчдыг мөн 5% байхаар тооцож байна.

Дээрх арга хэмжээг он дуустал хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын сангийн орлого анх батлагдсан дүнгээс нийт 880 орчим тэрбум төгрөгөөр буурах тооцоотой байгаа бөгөөд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс шийдвэрлэхээр тооцлоо.Үүнд:

1. Капитал банк татан буугдахад тус банканд байршиж байсан Нийгмийн даатгалын сангийн 104.2 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах.
2. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу компанийн гаргасан үнэт цаасыг Монголбанк эзэмших хүртэл хугацаа буюу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл арилжааны банканд байршуулсан Нийгмийн даатгалын сангийн 452.5 тэрбум төгрөгийг чөлөөлөх.

<u>Нийгмийн даатгалын сангийн зарлага</u>

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хүрээнд 2020 онд 88.0 орчим мянган иргэн хамрагдан тэтгэврийн даатгалын санд 133.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 34.8 мянган малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэвэрт 117.3 тэрбум төгрөг зарцуулахаар нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсөвт тусгагдсан боловч Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас 2020 оны эхний 5 сарын байдлаар 2911 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдан тэтгэврийн даатгалын шимтгэлд 4.6 тэрбум төгрөг төлсөн нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр жилийн эцэст 42.2 тэрбум төгрөг санд орж, 37.3 тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулахаар байна. Иймд хуулийг хэрэгжүүлэхэд хэмнэгдэж буй тэтгэврийн даатгалын сангийн зарлагын төсвийг 80.0 тэрбум төгрөгөөр бууруулж үүнээс ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх дэмжлэгт шаардагдах 64.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шилжүүлэн шийдвэрлэхээр тооцов.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон

болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан 6.9 мянган аж ахуйн нэгжийн 73 мянга орчим ажилчдад сард 200.000 төгрөг буюу нийт 25.2 тэрбум төгрөгийг олгосон ба хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 64 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоотой байгаа тул холбогдох зардлыг хэмнэлттэй байгаа сангаас шилжүүлэн шийдвэрлэхээр тооцлоо.

Цар тахлын үед эдийн засгийг сэргээж аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих, иргэдийн орлого, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр УИХ, Засгийн газраас хэрэгжүүлсэн багц арга хэмжээний зарим хэсгийг 2020 он дуустал үргэлжлүүлэх, үүнтэй холбогдуулан тэвчиж болох урсгал зардлыг боломжит хэмжээнд нь хүртэл бууруулах шаардлага үүсэж байгаатай холбоотойгоор сангийн үйл ажиллагааны зардлыг 0.6 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцов.

--oOo--

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 08 дугаар
сарын ..-ны өдөр Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ, АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай 2^1 дүгээр зүйл нэмсүгэй:

"2^1 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 болон 2 дугаар зүйлд заасан даатгуулагчийн 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх шимтгэлийг дараах байдлаар ногдуулна:

2^1.1.энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан ажил олгогч, даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийг тус бүр 5 хувиар;

2^1.2.энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийг 5 хувиар;

2^1.3.энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан ажил олгогч, даатгуулагчийн төлөх тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг энэ зүйлд заасан хугацаанд шимтгэл төлснөөр тооцно;

2^1.4.энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг энэ зүйлд заасан хугацаанд шимтгэл төлснөөр тооцно;"

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх" гэснийг "2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх" гэж, 5 дугаар зүйлийн "2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх" гэснийг "2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасны дагуу коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч, түүнчлэн сайн дураар даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлсөн. Уг арга хэмжээнд нийт 38.4 мянган аж ахуйн нэгжийн 401.8 мянган даатгуулагч, 144.3 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж 4, 5, 6 дугаар саруудад нийт 271 тэрбум төгрөгийн шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөөд байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж байгаа ажил олгогч болон даатгуулагчийн төлөх Нийгмийн даатгалын шимтгэлийг “тэглэсэн” арга хэмжээ 2020 оны 10 дугаар сарын 01-ээр дуусгавар болно. Төсвийн тодотголд уг арга хэмжээг 2020 оны 10-12 дугаар саруудад шимтгэлийн “хөнгөлөлт” байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд шимтгэл “тэглэх” арга хэмжээнд хамрагдсан аж ахуйн нэгж, даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогч 5%, даатгуулагч 5%, сайн дураар даатгуулагчийг мөн 5% байх хуулийн төсөл боловсруулав.

Хууль батлагдснаар Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед аж ахуйн нэгжийн санхүүгийн эрсдэл буурах бөгөөд энэ нь ажил олгогчийн хувьд нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаа бууруулах, даатгуулагчийн хувьд ажлын байран дээрээ цалин орлоготой үлдэх, цалингаа бүрэн авах, сайн дурын даатгуулагч хувьд шимтгэлийн хөнгөлөлт эдлэх зэрэг эерэг үр дагавартай байх болно.

--oOo--

4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ
САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСӨВТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтад "урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх" гэж тус тус заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Улирлын чанартай томуугийн дэгдэлт жилийн 10 дугаар сараас ихсэж хүндэрдэг нь дэлхий нийтийг хамраад байгаа Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас ялгахад хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгохоор байна. Иймд цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр эрүүл мэндийн салбарт 2020 онд зарцуулахаар батлагдсан хөрөнгөд улирлын томуу болон Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх вакцинд иргэдийг хамруулахад зориулж нэмэлт хөрөнгийг хуваарилах шаардлага бий болж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан орлогын хэмжээ, 4 дүгээр зүйлд заасан зарлагын хэмжээг тус тус өөрчлөх тухай нэг зүйлтэй байна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2020 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл

ажиллагаагаа хэрэгжүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт биелж, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй хамт Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

--- oOo ---

<u>ТӨСӨЛ</u>

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Эрүүл мэндийн сайд**	**506,538.3**
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	133,598.5
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	158,202.3
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	53,548.7
	1.4 Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	84,128.5
	1.5 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	19,425.8
	1.6 Бусад орлого	57,634.6
Нийт орлого		**506,538.3**

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Эрүүл мэндийн сайд**	**494,538.3**
	1.1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох	319,982.6
	Үүнээс: 1.1.1 Улсын төсөв	246,345.9
	1.1.2 Аж ахуйн тооцоот	42,629.4
	1.1.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв	8,707.3
	1.1.4 Ковид-19, улирлын томуугийн вакцин	22,300.0
	1.2 Хувийн эмнэлэгт олгох	130,548.5
	1.3 Эмийн санд олгох	37,228.8
	1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	5,438.4
	1.5 Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.0
	1.6 Бусад	240.0
Нийт зарлага		**494,538.3**

Гарын үсэг

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дараах зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт:

“9.1.9.Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1, 24.6.2, 24.6.5-24.6.9, 35^1.3-т заасан эмнэлгийн тусламж үйлчилгээ;”

2/14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалт:

“14.8.7.даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах;”

3/14 дүгээр зүйлийн 14.9.9 дэх заалт:

“14.9.9.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж, ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргах;”

4/23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалт:

“23.2.3.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх;”

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “хэлбэрийн” гэсний дараа “эмийн сангаас бусад” гэж, мөн заалтын “байгууллагаас” гэсний өмнө “тусламж, үйлчилгээ үзүүлэгч” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3.Даатгуулагч Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршлийн эмийг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмийн сан, бусад эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.”

2/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:

“9.4.Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.”

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

“9.1.5. Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.3, 15.1.8, 15.1.10, 15.1.14-т заасан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээ;”

4/9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт:

“9.1.7.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт;”

5/14 дүгээр зүйлийн 14.8.2 дахь заалт:

“14.8.2.эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн батлах;”

6/14 дүгээр зүйлийн 14.8.3 дахь заалт:

“14.8.3.эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;”

7/16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт:

“16.1.3.даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээ худалдан авах даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;”

8/16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт:

“16.1.5.даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;”

9/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:

“18.4.Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч, мэргэжилтэнд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт хангасан байдал, ажлын үр дүнг үндэслэн бүтээмжийн урамшуулал олгох бөгөөд холбогдох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5, 9.1.7, 9.1.9, 9.1.10, 9.1.11 дэх заалтын дугаарыг “9.1.4”, “9.1.5”, “9.1.6”, “9.1.7”, “9.1.8” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “байгууллагатай” гэснийг “байгууллага болон эмийн сантай” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Нийгмийн” гэснийг “эрүүл мэндийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.8 дахь заалтын “тариа, материалын” гэснийг “эмнэлгийн хэрэгслийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.9.8, 14.9.10, 14.9.11 дэх заалтын “нийгмийн даатгалын” гэснийг “санхүү, төсвийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалтын дугаарыг “14.8.8” гэж, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн “банкинд” гэснийг “төрийн санд” гэж, 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалтын дугаарыг “23.2.4” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “нийгмийн даатгалын,” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.8 дахь заалтын “магадлан итгэмжлэгдсэн спортын клуб,” гэснийг, 3.1.7 дахь заалтын “идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.6, 9.1.8, 9.1.12 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.9.9 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйл дор дурдсан агуулгатай 24.6.9 дэх заалт нэмсүгэй:

“24.6.9.эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ;”

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Энэ хуулийн 24.6.3, 24.6.4-т заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх болон хяналт тавих журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

2/24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг:

“24.4.Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлсэн энэ хуулийн 24.6.9-т заасан тусламж, үйлчилгээнээс бусад тусламж, үйлчилгээний төлбөрийг тухайн иргэнээс авна.”

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалтын “, эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:

“3.1.8.“тохиолдолд суурилсан төлбөрийн арга” гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тохиолдол бүрээр зардлыг урьдчилж багцлан тооцож санхүүжүүлэхийг.”

2/ 16 дугаар зүйлийн 16.6.4 дэх заалт:

“16.6.4. батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах, төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон цалингийн санд багтаан ажилтны ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, ажилтны нийгмийн баталгааг хангах, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан зохицуулалтын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2020 онд улсын төсвөөс 680.0 тэрбум, Эрүүл мэндийн даатгал(ЭМД)-ын сангаас 506.0 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж байна. Төр зардлыг нь хариуцах өвчний эмчилгээнд хуваарилсан хөрөнгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэхэд зориулж байгаа бол ЭМД-ын сангаас олгох санхүүжилтийг төрийн өмчийн эмнэлэгт хийгдэж байгаа эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, хэвтүүлэн эмчлэхэд, харин хувийн эмнэлгүүдэд зөвхөн хэвтүүлэн эмчлүүлсэн үед тохиолдлын тоонд үндэслэн нөхөн төлбөр олгож байна.

Эрүүл мэндийн салбарын одоогийн санхүүжилтийн тогтолцооны үр дагавар нь улсын эмнэлгүүдийн ачаалал, хүлээгдэл, иргэний бухимдлыг бий болгож, хувийн эмнэлгээс үйлчилгээ авсан орлого багатай иргэд санхүүгийн эрсдэлд орж байна. Улсын эмнэлгүүдийн эмч, ажилчдын ажлын ачаалал, гүйцэтгэлтэй уялдсан цалин, урамшууллын механизмгүйгээс иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх сонирхлыг бууруулж байна. Түүнчлэн ЭМД-ын сангаас зөвхөн өрх, сумын эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт олгож байгаа нь өрхийн эмчийн ачааллыг нэмэгдүүлж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд сүүлийн жилүүдэд холбогдох судалгаа, шинжилгээ хийж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлага, арга замуудыг тодорхойлсон бөгөөд ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, санхүүгийн бэрхшээлийг арилгахад чиглэсэн тогтолцооны шинэчлэлийг нэн даруй хийх нь зүйтэй гэж үзсэн болно.

Иргэд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас өвчин, эмгэгийн төрлөөс үл хамааран шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, шуурхай авдаг болох зорилгоор эрүүл мэндийн салбарт хуваарилах санхүүжилтийг нэг худалдан авагчийн зарчмаар буюу эрүүл мэндийн даатгалын байгууллага нэгдсэн байдлаар(улсын төсвийн санхүүжилтийн хамт)зохицуулдаг байхаар тооцож холбогдох хуулийн төслүүдийг боловсруулав.

Хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлт орсноор улсын төсвийн одоогийн санхүүжилтийг өвчин, эмгэгийн нэр төрөл, тусламж, үйлчилгээний өртөг, тоо

хэмжээнд үндэслэн тооцож эрүүл мэндийн даатгалын санд жил бүр шилжүүлэх болно. Ингэснээр иргэн эрүүл мэндийн даатгалаараа эмнэлгийн бүх төрлийн тусламж, үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй авах, бүх шатлалын эмнэлгийн эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт авах боломж бүрдэнэ.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг үр дүнтэй болгох зорилгоор эрүүл мэндийн даатгалын байгууллагын зүгээс иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээнд тавих чанарын хяналтыг сайжруулах, эмнэлгийн үйлчилгээг олон улсын жишигт ойртуулах, мэдээллийг цахимжуулах, эрүүл мэндийн байгууллагын эмч, ажиллагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг тусгасан болно

Хуулийн төслүүд батлагдсанаар эрүүл мэндийн салбарт олон жил хуримтлагдсан санхүүжилтийн асуудал цэгцэрч, иргэдэд учирдаг үйлчилгээний чирэгдэл болон төлбөрийн дарамт арилж, эрүүл мэндийн салбарын ажиллагчдын нийгмийн баталгаа сайжрах болно.

--oOo--

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг:

“4.4.Эмийн үндэсний бодлого нь Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын бодлогод тусаж, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар дамжин хэрэгжинэ.”

2/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянана.”

3 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.3, 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Дугаар | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь**:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “24.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төсөл

Эм, эмнэлгийн хэрэгсэл нь онцгой бараа бүтээгдэхүүн бөгөөд дэлхийн улс орнууд үндэсний аюулгүй байдлын хүрээнд авч үзэж төрөөс хяналт, зохицуулалт хийдэг. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 2013 онд хийсэн үнэлгээгээр Монгол улс эмийн зах зээл дээр байгаа 3 эм тутмын 1 нь хуурамч, эмийн үнэ ДЭМБ-аас гаргасан олон улсын жишгээс 5-6 дахин үнэтэй, чанаргүй байгааг тогтоосон байна.

Дээрх асуудлын үр дагавар нь иргэд антибиотикийн "замбараагүй" хэрэглээтэй болох, эмэнд дасалтай болох, өвчин эдгэхгүй байх, иргэд санхүүгийн эрсдэлд нэрвэгдэх зэрэгт хүргэж байна. ДЭМБ-ын зүгээс эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг хийх, тус асуудлыг эрхэлсэн тусгай чиг үүрэг бүхий байгууллага байгуулахыг зөвлөмж болгосон хэдий ч одоог хүртэл хэрэгжихгүй байна.

ДЭМБ-ын мэдээллээр НҮБ-д бүртгэлтэй 119 улс нь эмийн нэгдсэн зохицуулалтын байгууллагатай бөгөөд Монгол улс нь эмийн зохицуулалтыг нэгтгэсэн бие даасан байгууллагагүй цөөн улсын нэг юм. Олон улсад байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалт хийж байгаа чиг үүргүүдийн ердөө 46.9 хувийг Монгол Улс хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогийн хяналт нь өөр төрлийн чиг үүрэг хариуцдаг төрийн байгууллагуудын бүтцэд салангид харилцан уялдаагүй байдлаар явж байна.

Иймд хуулийн төсөлд "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага"-тай байхыг хуульчлах, мөн үүнтэй холбогдуулан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт "24.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар" гэж нэмж тусгахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулав.

Хууль хэрэгжсэнээр эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн зохицуулалттай болж чанар аюулгүй байдал дээшлэх, эмийн үнэ буурах, хуурамч эмийн импорт буурч, эмчилгээ, үйлчилгээний чанарт нөлөөлөх зэрэг эерэг үр дагавартай байх болно.

--oOo--

5.ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

“Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай” хуулиудыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган, байнгын хороодоор хэлэлцүүлэхтэй холбоотой Сангийн яамнаас оролцох ажлын хэсгийн хүмүүсийн нэрс:

Д/Д	Нэр	Албан тушаал
1	Ч.Хүрэлбаатар	Сангийн сайд
2	С.Мөнгөнчимэг	Сангийн дэд сайд
3	С.Наранцогт	Төрийн нарийн бичгийн дарга
4	Ж.Ганбат	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
5	Г.Түвдэндорж	Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга
6	Ц.Зоригтбат	Санхүүгийн бодлогын газрын дарга
7	Г.Батхүрэл	Эдийн засгийн бодлогын газрын дарга
8	И.Батхүү	Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга
9	З.Энхболд	Хууль эрх зүйн газрын дарга
10	М.Санжаадорж	Төсвийн зарлагын хэлтсийн дарга
11	Б.Тэлмүүн	Төсвийн орлогын хэлтсийн дарга
12	Г.Золбоо	Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга
13	Б.Сүх-очир	Өрийн удирдлагын хэлтсийн дарга
14	Л.Сонор	Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга
15	С.Тулга	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
16	Л.Ичинноров	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
17	Г.Гантулга	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
18	З.Анар	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
19	Э.Батмөнх	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
20	С.Тэмүүжин	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
21	Т.Батсүх	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
22	Э.Номин-Эрдэнэ	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
23	Н.Уранцэцэг	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
24	Д.Отгонжаргал	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч
25	Н.Оюун-Эрдэнэ	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
26	В.Содномдаржаа	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
27	П.Бат-эрдэнэ	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
28	Ж.Ганбаяр	Эдийн засгийн бодлогын газрын шинжээч
29	С.Сүхдэлгэр	Эдийн засгийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
30	Л.Гантогтох	Санхүүгийн бодлогын газрын мэргэжилтэн
31	М.Мөнх-Эрдэнэ	Санхүүгийн бодлогын газрын мэргэжилтэн
32	Н.Сансармаа	Хөгжлийн санхүүжилтийн газрын мэргэжилтэн
33	К.Гүлжан	Хууль эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт №1

/сая төгрөг/

	2020 тод төсөл							
	НЭГДСЭН ТӨСӨВ		УЛСЫН ТӨСӨВ			Орон нутаг	НДС	ЭМДС
			НИЙТ	Төсвөөс санхүүжих	Гадаад зээл, тусламжаас санхүүжих			
	2020 Тод.							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**10,729,282.8**		**8,474,887.4**	**8,324,587.3**	**150,300.2**	**3,165,727.7**	**1,812,258.7**	**506,538.3**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**55,151.2**		**55,151.2**	**55,151.2**				
ИРЭЭДҮЙН ӨВ САН	**943,205.0**		**943,205.0**	**943,205.0**				
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**9,730,926.6**	**25.2%**	**7,476,531.2**	**7,326,231.1**	**150,300.2**	**3,165,727.7**	**1,812,258.7**	**506,538.3**
1. Татварын орлого	**8,847,130.2**		**6,095,810.8**	**6,095,810.8**	**0.0**	**1,231,137.0**	**1,411,741.1**	**506,538.3**
1.1. Орлогын албан татвар	2,593,800.8		1,736,434.1	1,736,434.1	0.0	857,366.7	0.0	0.0
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	857,366.7		0.0	0.0	0.0	857,366.7	0.0	0.0
1.1.2. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	1,736,434.1		1,736,434.1	1,736,434.1	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын орлого	1,520,182.3		0.0	0.0	0.0	0.0	1,411,741.1	506,538.3
1.3. Хөрөнгийн албан татвар	152,654.5		0.0	0.0	0.0	152,654.5	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,277,958.5		2,277,958.5	2,277,958.5	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	734,906.1		734,906.1	734,906.1	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	15,957.9		15,957.9	15,957.9	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	770,967.0		770,967.0	770,967.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	780,703.0		559,587.2	559,587.2	0.0	221,115.8	0.0	0.0
2. Татварын бус орлого	**883,796.4**		**1,380,720.4**	**1,230,420.2**	**150,300.2**	**1,934,590.6**	**400,517.6**	**0.0**
2.1. Нийтлэг татварын бус орлого	732,746.3		602,828.5	602,828.5	0.0	129,917.8	0.0	0.0
2.2. Хөрөнгийн орлого	750.0		0.0	0.0	0.0	750.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	150,300.2		150,300.2	0.0	150,300.2	0.0	0.0	0.0
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0		627,591.7	627,591.7	0.0	1,803,922.9	400,517.6	0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**14,577,486.9**	**37.7%**	**11,653,262.0**	**10,030,101.8**	**1,623,160.2**	**3,165,772.7**	**2,494,043.3**	**494,538.3**
А. УРСГАЛ ЗАРЛАГА	**11,154,296.4**		**8,812,016.7**	**8,477,169.6**	**334,847.1**	**2,583,827.4**	**2,494,043.3**	**494,538.3**
1. Бараа, үйлчилгээний зардал	**4,961,580.4**		**3,154,385.8**	**2,831,597.7**	**322,788.1**	**2,075,676.2**	**26,466.6**	**5,258.8**
1.1. Цалин, хөлс	2,656,456.3		1,427,375.3	1,420,119.6	7,255.7	1,208,328.1	18,761.7	1,991.1
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0		134,336.8	133,296.4	1,040.4	163,085.3	2,533.7	251.2
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	2,305,124.1		1,592,673.7	1,278,181.7	314,492.0	704,262.8	5,171.2	3,016.4
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**972,576.4**		**972,576.4**	**972,576.4**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
3. Татаас ба урсгал шилжүүлэг	**5,220,139.6**		**4,685,054.5**	**4,672,995.5**	**12,059.0**	**508,151.2**	**2,467,576.7**	**489,279.6**
3.1. Татаас	362,781.6		629,638.8	629,638.8	0.0	81,724.7	0.0	50,835.8
3.2. Урсгал шилжүүлэг	4,857,358.0		4,055,415.7	4,043,356.7	12,059.0	426,426.6	2,467,576.7	438,443.8
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**3,408,575.5**		**2,826,630.2**	**1,762,826.5**	**1,063,803.7**	**581,945.2**	**0.0**	**0.0**
1. Барилга байгууламж	2,143,193.0		2,102,193.0	1,384,865.4	717,327.6	41,000.0	0.0	0.0
2. Их засвар	131,418.0		131,418.0	112,469.0	18,949.0	0.0	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	477,873.7		477,873.7	157,573.6	320,300.1	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	636,311.0		95,365.7	88,138.8	7,226.9	540,945.2	0.0	0.0
5. Стратегийн нөөц хөрөнгө	19,779.7		19,779.7	19,779.7	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**14,615.0**		**14,615.0**	**-209,894.3**	**224,509.3**	**0.0**	**0.0**	**0.0**
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-209,894.3		-209,894.3	-209,894.3	0.0	0.0	0.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	224,509.3		224,509.3	0.0	224,509.3	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (НИЙТ ОРЛОГООР ТООЦСОН)	**-3,848,204.1**	**-9.9%**						
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	**-4,846,560.3**	**-12.5%**	**-4,176,730.8**	**-2,703,870.8**	**-1,472,860.0**	**-45.0**	**-681,784.5**	**12,000.0**
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**4,846,560.3**		**4,176,730.8**	**2,703,870.8**	**1,472,860.0**	**45.0**	**681,784.5**	**-12,000.0**
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	**0.0**		**-669,784.5**	**1,860,783.0**	**-1,597,829.0**	**0.0**	**681,784.5**	**-12,000.0**
2. ЗГ-ын үнэт цаас	**932,738.5**		**932,738.5**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
2.1. Урт хугацаат	932,738.5		932,738.5	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.1. Дотоод	932,738.5		932,738.5		0.0	0.0	0.0	0.0
2.1.1.1. Шинээр гаргах	1,195,743.1		1,195,743.1	1,195,743.1				
2.1.1.2. Үндсэн төлбөр	-263,004.6		-263,004.6	-263,004.6				
3. ЗГ-ын зээл	**3,311,289.0**		**3,311,289.0**	**240,600.0**	**3,070,689.0**	**0.0**	**0.0**	**0.0**
3.1. Дотоод	240,600.0		240,600.0	240,600.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2. Авлага	240,600.0		240,600.0	240,600.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.1. Шинээр үүсгэх	240,600.0		240,600.0	240,600.0				
3.2. Гадаад	3,070,689.0		3,070,689.0	0.0	3,070,689.0	0.0	0.0	0.0
3.2.1. Төслийн зээл	748,696.6		748,696.6	0.0	748,696.6	0.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр авах	1,472,860.0		1,472,860.0		1,472,860.0			
3.2.1.2. Үндсэн төлбөр	-724,163.4		-724,163.4		-724,163.4			
3.2.2. Хөтөлбөрийн зээл	2,321,992.4		2,321,992.4	0.0	2,321,992.4	0.0	0.0	0.0
3.2.2.1. Шинээр авах	2,321,992.4		2,321,992.4		2,321,992.4			
4. НДС-ийн арилжааны банкнаас авах шилжүүлэг	**452,500.0**		**452,500.0**	**452,500.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
5. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	**149,747.8**		**149,747.8**	**149,747.8**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
6. Өмч хувьчлал	**285.0**		**240.0**	**240.0**	**0.0**	**45.0**	**0.0**	**0.0**

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ - ДНБ-д харьцуулсан

Хавсралт №2

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ЭМДС	ОРОН НУТАГ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**27.73**	**21.91**	**4.68**	**1.31**	**8.18**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**0.14**	**0.14**	**0.00**	**0.00**	**0.00**
ИРЭЭДҮЙН ӨВ САН	**2.44**	**2.44**	**0.00**	**0.00**	**0.00**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**25.15**	**19.33**	**4.68**	**1.31**	**8.18**
1. Татварын орлого	**22.87**	**15.76**	**3.65**	**1.31**	**3.18**
1.1. Орлогын албан татвар	6.70	4.49	0.00	0.00	2.22
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	2.22	0.00	0.00	0.00	2.22
1.1.2. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	4.49	4.49	0.00	0.00	0.00
1.2. Нийгмийн даатгалын орлого	3.93	0.00	3.65	1.31	0.00
1.3. Хөрөнгийн албан татвар	0.39	0.00	0.00	0.00	0.39
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	5.89	5.89	0.00	0.00	0.00
1.5. Онцгой албан татвар	1.90	1.90	0.00	0.00	0.00
1.6. Тусгай зориулалтын орлого	0.04	0.04	0.00	0.00	0.00
1.7. Гаалийн албан татвар	1.99	1.99	0.00	0.00	0.00
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	2.02	1.45	0.00	0.00	0.57
2. Татварын бус орлого	**2.28**	**3.57**	**1.04**	**0.00**	**5.00**
2.1. Нийтлэг татварын бус орлого	1.89	1.56	0.00	0.00	0.34
2.2. Хөрөнгийн орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
2.3. Тусламжийн орлого	0.39	0.39	0.00	0.00	0.00
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	1.62	1.04	0.00	4.66
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**37.68**	**30.12**	**6.45**	**1.28**	**8.18**
А. УРСГАЛ ЗАРЛАГА	**28.83**	**22.78**	**6.45**	**1.28**	**6.68**
1. Бараа, үйлчилгээний зардал	**12.82**	**8.15**	**0.07**	**0.01**	**5.37**
1.1. Цалин, хөлс	6.87	3.69	0.05	0.01	3.12
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.00	0.35	0.01	0.00	0.42
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	5.96	4.12	0.01	0.01	1.82
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**2.51**	**2.51**	**0.00**	**0.00**	**0.00**
3. Татаас ба урсгал шилжүүлэг	**13.49**	**12.11**	**6.38**	**1.26**	**1.31**
3.1. Татаас	0.94	1.63	0.00	0.13	0.21
3.2. Урсгал шилжүүлэг	12.56	10.48	6.38	1.13	1.10
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**8.81**	**7.31**	**0.00**	**0.00**	**1.50**
1. Барилга байгууламж	5.54	5.43	0.00	0.00	0.11
2. Их засвар	0.34	0.34	0.00	0.00	0.00
3. Тоног төхөөрөмж	1.24	1.24	0.00	0.00	0.00
4. Бусад хөрөнгө	1.64	0.25	0.00	0.00	1.40
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.05	0.05	0.00	0.00	0.00
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**0.04**	**0.04**	**0.00**	**0.00**	**0.00**
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-0.54	-0.54	0.00	0.00	0.00
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.58	0.58	0.00	0.00	0.00
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	**-12.53**	**-10.80**	**-1.76**	**0.03**	**0.00**
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	**38,688,249.2**	**38,688,249.2**	**38,688,249.2**	**38,688,249.2**	**38,688,249.2**

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

/сая төгрөг/ /ДНБ-д эзлэх хувь/

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2020	Зөрүү	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2020
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Бат	Бат	Тод төсөл		Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Бат	Бат	ТТөсөл
	.1.	.2.	.3.	.4.	.5.	.6.	.7.	.8.	.9.	.9-8.	.1.	.2.	.3.	.4.	.5.	.6.	.7.	.8.	.9.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,986,925.2	6,316,522.6	5,983,397.7	5,835,043.8	7,958,264.6	10,172,760.3	11,067,000.0	12,900,000.0	10,729,282.8	-2,170,717.2	34.1	28.8	25.8	24.4	29.3	31.6	31.3	31.7	27.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	46,858.6	39,913.8	2,333.7	0.0	325,680.2	206,986.6	322,000.0	125,200.0	55,151.2	-70,048.8	0.3	0.2	0.0	0.0	1.2	0.6	0.9	0.3	0.1
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.0	0.0	0.0	0.0	357,722.8	620,693.6	1,068,520.0	976,960.0	943,205.0	-33,755.0	0.0	0.0	0.0	0.0	1.3	1.9	3.0	2.4	2.4
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,940,066.7	6,276,608.8	5,981,064.0	5,835,043.8	7,274,861.6	9,345,080.1	9,676,480.0	11,797,840.0	9,730,926.6	-2,066,913.4	33.8	28.6	25.8	24.4	26.8	29.1	27.4	29.0	25.2
1. Татварын орлого	**5,072,793.3**	**5,157,024.5**	**5,118,979.4**	**4,950,950.2**	**6,315,131.9**	**8,227,776.1**	**8,585,770.0**	**10,656,151.7**	**8,847,130.2**	**-1,809,021.5**	**28.9**	**23.5**	**22.1**	**20.7**	**23.2**	**25.6**	**24.3**	**26.2**	**22.9**
1.1. Орлогын албан татвар	1,109,204.9	1,101,030.2	1,170,831.3	1,043,368.7	1,613,192.8	2,091,089.9	2,016,000.0	2,764,690.0	2,593,800.8	-170,889.2	6.3	5.0	5.1	4.4	5.9	6.5	5.7	6.8	6.7
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	449,045.9	479,793.2	482,334.5	523,410.0	651,047.9	814,158.5	776,000.0	914,690.0	857,366.7	-57,323.3	2.6	2.2	2.1	2.2	2.4	2.5	2.2	2.2	2.2
1.1.2 Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	660,159.0	621,237.0	688,496.8	519,958.7	962,144.9	1,276,931.4	1,240,000.0	1,850,000.0	1,736,434.1	-113,565.9	3.8	2.8	3.0	2.2	3.5	4.0	3.5	4.5	4.5
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	874,229.2	917,589.8	1,018,152.9	1,109,757.4	1,321,375.2	1,638,321.1	1,697,280.0	2,402,749.7	1,520,182.3	-882,567.3	5.0	4.2	4.4	4.6	4.9	5.1	4.8	5.9	3.9
1.3. Хөрөнгийн албан татвар	43,975.4	50,109.4	86,610.1	104,659.9	131,129.6	141,225.4	138,170.0	164,770.0	152,654.5	-12,115.5	0.3	0.2	0.4	0.4	0.5	0.4	0.4	0.4	0.4
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,435,091.6	1,371,725.4	1,049,588.7	1,140,721.4	1,618,492.1	2,195,907.2	2,321,100.0	2,625,900.0	2,277,958.5	-347,941.5	8.2	6.3	4.5	4.8	6.0	6.8	6.6	6.5	5.9
1.5. Онцгой албан татвар	449,410.3	454,390.3	592,323.6	630,124.8	519,721.5	754,440.2	837,800.0	953,400.0	734,906.1	-218,493.9	2.6	2.1	2.6	2.6	1.9	2.3	2.4	2.3	1.9
1.6. Тусгай зориулалтын орлого	36,688.4	39,862.8	11,791.8	10,767.4	12,386.6	13,063.7	12,200.0	15,900.0	15,957.9	57.9	0.2	0.2	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	381,427.0	355,328.9	320,594.9	328,490.6	512,351.2	682,218.2	743,020.0	874,722.0	770,967.0	-103,755.0	2.2	1.6	1.4	1.4	1.9	2.1	2.1	2.2	2.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	742,766.6	866,987.9	869,086.2	583,060.0	586,482.8	711,510.3	820,200.0	854,020.0	780,703.0	-73,317.0	4.2	4.0	3.8	2.4	2.2	2.2	2.3	2.1	2.0
2. Татварын бус орлого	**867,273.4**	**1,119,584.3**	**862,084.7**	**884,093.5**	**959,729.8**	**1,117,304.0**	**1,090,710.0**	**1,141,688.4**	**883,796.4**	**-257,891.9**	**4.9**	**5.1**	**3.7**	**3.7**	**3.5**	**3.5**	**3.1**	**2.8**	**2.3**
2.1. Нийтлэг татварын бус орлого	860,560.9	1,094,468.1	753,507.1	805,424.9	896,708.4	1,027,675.0	944,130.0	990,658.2	732,746.3	-257,911.9	4.9	5.0	3.3	3.4	3.3	3.2	2.7	2.4	1.9
2.2. Хөрөнгийн орлого	6,712.5	25,116.3	55,137.9	1,487.3	1,187.9	1,123.6	580.0	730.0	750.0	20.0	0.0	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	0.0	0.0	53,439.6	77,181.3	61,833.5	88,505.4	146,000.0	150,300.2	150,300.2	0.0	0.0	0.0	0.2	0.3	0.2	0.3	0.4	0.4	0.4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	6,164,685.3	7,144,568.0	7,137,973.9	9,495,332.9	9,017,318.6	9,317,220.8	11,589,094.1	13,872,581.7	14,577,486.9	704,905.2	35.1	32.6	30.8	39.8	33.2	29.0	32.8	34.1	37.7
А. УРСГАЛ ЗАРЛАГА	4,552,606.6	5,293,361.6	5,718,373.8	6,613,809.1	7,043,161.7	7,350,338.9	8,217,300.3	10,019,361.4	11,154,296.4	1,134,935.0	25.9	24.1	24.7	27.7	25.9	22.9	23.3	24.6	28.8
1. Бараа, үйлчилгээний зардал	**2,391,174.1**	**2,652,480.8**	**2,801,673.1**	**3,133,289.2**	**3,141,432.3**	**3,327,510.9**	**3,947,539.9**	**4,785,518.3**	**4,961,580.4**	**176,062.1**	**13.6**	**12.1**	**12.1**	**13.1**	**11.6**	**10.3**	**11.2**	**11.8**	**12.8**
1.1. Цалин, хөлс	1,401,530.8	1,586,419.5	1,709,772.9	1,746,794.8	1,800,434.6	1,878,939.8	2,215,239.3	2,627,990.1	2,656,456.3	28,466.2	8.0	7.2	7.4	7.3	6.6	5.8	6.3	6.5	6.9
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	989,643.3	1,066,061.3	1,091,900.2	1,386,494.4	1,340,997.7	1,448,571.1	1,732,300.6	2,157,528.2	2,305,124.1	147,596.0	5.6	4.9	4.7	5.8	4.9	4.5	4.9	5.3	6.0
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**270,442.1**	**500,351.2**	**731,055.1**	**986,099.8**	**1,156,465.1**	**1,046,419.8**	**865,585.5**	**959,781.5**	**972,576.4**	**12,794.9**	**1.5**	**2.3**	**3.2**	**4.1**	**4.3**	**3.3**	**2.4**	**2.4**	**2.5**
3. Татаас ба урсгал шилжүүлэг	**1,890,990.3**	**2,140,529.6**	**2,185,645.6**	**2,494,420.0**	**2,745,264.2**	**2,976,408.1**	**3,404,174.9**	**4,274,061.6**	**5,220,139.6**	**946,078.0**	**10.8**	**9.8**	**9.4**	**10.4**	**10.1**	**9.3**	**9.6**	**10.5**	**13.5**
3.1. Татаас	175,838.7	167,195.4	101,482.0	229,325.3	260,619.2	230,028.7	251,713.5	374,749.7	362,781.6	-11,968.1	1.0	0.8	0.4	1.0	1.0	0.7	0.7	0.9	0.9
3.2. Урсгал шилжүүлэг	1,715,151.6	1,973,334.2	2,084,163.5	2,265,094.8	2,484,645.0	2,746,379.4	3,152,461.3	3,899,311.9	4,857,358.0	958,046.1	9.8	9.0	9.0	9.5	9.1	8.5	8.9	9.6	12.6
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,490,741.7	1,771,069.2	1,396,704.6	2,360,210.2	1,658,140.7	1,680,430.2	3,243,688.4	3,806,087.3	3,408,575.5	-397,511.8	8.5	8.1	6.0	9.9	6.1	5.2	9.2	9.4	8.8
1. Барилга байгууламж	1,253,958.7	1,505,934.2	614,548.4	1,576,950.9	1,121,662.4	1,094,604.5	2,202,405.7	2,512,690.1	2,143,193.0	-369,497.1	7.1	6.9	2.7	6.6	4.1	3.4	6.2	6.2	5.5
2. Их засвар	88,079.0	91,874.8	110,773.2	129,004.7	66,992.7	89,888.4	156,996.7	157,642.2	131,418.0	-26,224.2	0.5	0.4	0.5	0.5	0.2	0.3	0.4	0.4	0.3
3. Тоног төхөөрөмж	103,003.3	142,233.0	73,837.4	0.0	0.0	0.0	292,105.8	402,872.4	477,873.7	75,001.3	0.6	0.6	0.3	0.0	0.0	0.0	0.8	1.0	1.2
4. Бусад хөрөнгө	12,626.7	12,836.1	136,065.3	401,482.3	469,485.7	495,937.3	571,300.6	710,552.9	636,311.0	-74,242.0	0.1	0.1	0.6	1.7	1.7	1.5	1.6	1.7	1.6
5. Стратегийн нөөц хөрөнгө	33,073.9	18,191.1	27,829.7	0.0	0.0	0.0	20,879.7	22,329.7	19,779.7	-2,550.0	0.2	0.1	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.1	0.1
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	433,650.6	252,772.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.9	1.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	121,337.0	80,137.1	22,895.4	521,313.6	316,016.2	286,451.7	128,105.4	47,133.0	14,615.0	-32,518.0	0.7	0.4	0.1	2.2	1.2	0.9	0.4	0.1	0.0
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	104,701.5	10,715.4	-17,588.9	487,553.2	200,817.3	179,613.3	7,105.4	-186,734.8	-209,894.3	-23,159.4	0.6	0.0	-0.1	2.0	0.7	0.6	0.0	-0.5	-0.5
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	16,635.5	69,421.7	40,484.3	33,760.4	115,198.9	106,838.4	121,000.0	233,867.9	224,509.3	-9,358.5	0.1	0.3	0.2	0.1	0.4	0.3	0.3	0.6	0.6
											0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-224,618.7	-867,959.1	-1,156,909.8	-3,660,289.1	-1,742,456.9	27,859.3	-1,912,614.1	-2,074,741.7	-4,846,560.3	-2,771,818.6	-1.3	-4.0	-5.0	-15.3	-6.4	0.1	-5.4	-5.1	-12.5
